



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-42</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>43-92</i>
<hr/>	
<i>1. Хуулийн төслүүдийг эцэслэн батлах /Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд/</i>	<i>47-50</i>
<hr/>	
<i>2. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>50-52</i>
<hr/>	
<i>3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>52-53</i>
<hr/>	
<i>4. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>53-55</i>
<hr/>	
<i>5. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>55-92</i>
<hr/>	

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 07-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 07 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: П.Анужин, Х.Баделхан, Б.Баттөмөр, Д.Ганбат, Ц.Даваасүрэн, Н.Наранбаатар, Д.Өнөрболор, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Ц.Сэргэлэн, Д.Цогтбаатар, Б.Энх-Амгалан, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ё.Баатарбилэг, Х.Болорчулуун, Л.Оюун-Эрдэнэ, Б.Чойжилсүрэн;

Тасалсан: Н.Ганибал;

Хоцорсон: Ш.Адьяа-31 минут, С.Амарсайхан-2 цаг 05 минут, Ц.Анандбазар-04 минут, Т.Аубакир-1 цаг 03 минут, С.Батболд-1 цаг 34 минут, Э.Батиугар-07 минут, Х.Булгантуяа-10 минут, Б.Жавхлан-1 цаг 02 минут, С.Одонтуяа-10 минут, Ж.Сүхбаатар-29 минут, Ц.Туваан-2 цаг 06 минут, Ж.Эрдэнэбат-1 цаг 42 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ч.Хүрэлбаатар нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ч.Хүрэлбаатар нар үг хэлэв.

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах /Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ч.Батбямба, Л.Батмөнх нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 5

Бүгд: 44

88.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 5
Бүгд: 44

88.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 3
Бүгд: 44

93.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 4
Бүгд: 44

90.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 3
Бүгд: 44

93.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

1. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 6
Бүгд: 44

86.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 4
Бүгд: 44

90.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 3
Бүгд: 44

93.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2. Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 3
Бүгд: 44

93.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 5
Бүгд: 44

88.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4. Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 5
Бүгд: 44

88.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 4
Бүгд: 44

90.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 5
Бүгд: 44

88.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7. Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 4

Бүгд: 44

90.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8. Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 3

Бүгд: 44

93.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 3

Бүгд: 44

93.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 4

Бүгд: 44

90.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

11. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 4

Бүгд: 44

90.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

12. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 5

Бүгд: 44

88.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

13. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 3

Бүгд: 44

93.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

14. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 3

Бүгд: 45

93.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

15. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 4

Бүгд: 45

91.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

16. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 4

Бүгд: 45

91.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

17. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 5

Бүгд: 45

88.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

18. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 3

Бүгд: 45

93.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

19. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 4

Бүгд: 45

91.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

20. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 6

Бүгд: 46

87.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

21. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 4

Бүгд: 46

91.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

22. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 3

Бүгд: 46

93.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

23. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 4

Бүгд: 46

91.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

24. Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 5

Бүгд: 46

89.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

25. “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 6

Бүгд: 46

87.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулж дууслаа.

Уг асуудлыг 10 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.04-ний өдөр өргөн

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений тавьсан асуултад Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба нар хариулж, тайлбар хийв.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, мөн яамны Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Гэрээ, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Б.Нямсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх

С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, мөн яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, С.Бямбацогт нарын тавьсан асуултад Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис нар хариулж, тайлбар хийв.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1. Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1. Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Э.Батшугар, Н.Ганибал, Ц.Идэрбат, Б.Саранчимэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “18.4.10,” гэснийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “гэснийг, 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон төсөлд нэмж тусгах:

“3 дугаар зүйл. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “15.2 дахь хэсэг,” гэснийг “15.2 дахь хэсгийн “хүсэлтээ бичгээр” гэсний дараа” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

“2 дугаар зүйл.Арбитрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “гарын үсэг зурна.” гэснийг “гарын үсгээр баталгаажуулна.” гэж өөрчилсүгэй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 21
Бүгд: 41
48.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалтад доор дурдсан агуулгатай 47.4 дэх хэсэг нэмэх:

“47.4.Цаасан хэлбэрээр давхар хадгалах цахим баримт бичгийн нэр төрлийг энэ хуулийн 6.1.11-д заасан жагсаалтад тусгайлан заана.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “мөн зүйлийн “4.1.14” гэснийг “4.1.15” гэж,” гэснийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.5.5 дахь заалтын, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.3.1, 26.3.4 дэх заалтын, мөн зүйлийн 26.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 17.1-д заасан цахим хэлбэрээр” гэж, 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, дугаарыг өөрчлөх.

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.1, 26.3.4 дэх заалтын, мөн зүйлийн 26.4 дэх хэсгийн “өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэх” гэснийг “энэ тухай бүртгэлд тэмдэглэх” гэж тус тус өөрчлөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн, 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийн, 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь заалтын, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн, “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “хэсэг, 33 дугаар зүйлийн 33.4.2 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэснийг “хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 33 дугаар зүйлийн 33.4.2 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж” тус тус нэмсүгэй.” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1, 2 дугаар зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Валютын зохицуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “худалдах, зээлдүүлэх гэрээ,” гэснийг “худалдах, зээлдүүлэх гэрээг бичгээр, эсхүл

цахим хэлбэрээр,” гэж, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 3 дахь заалтын “нотолгоо бичгээр” гэснийг “нотолгоог бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Гаалийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн, 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн, 90 дүгээр зүйлийн 90.2, 90.3 дахь хэсгийн, 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 139 дүгээр зүйлийн 139.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-г заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 253 дугаар зүйлийн 253.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 255 дугаар зүйлийн 255.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Гаалийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2.2 дахь заалтын “мэдээллийн сүлжээгээр” гэснийг “цахим хэлбэрээр” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Гаалийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн гарчгийн “амаар болон бичгээр” гэснийг, 145 дугаар зүйлийн 145.1.9 дэх заалтын “бичгээр” гэснийг, 241 дүгээр зүйлийн 241.2 дахь хэсгийн “амаар болон бичгээр” гэснийг тус тус хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

12. Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Газрын тосны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын, 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын, 8.6 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсгийн, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсгийн, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсгийн, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн, 55 дугаар зүйлийн 55.1, 55.3 дахь хэсгийн, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн, 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсгийн, 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсгийн, 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсгийн, 81 дүгээр зүйлийн 81.2.7 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн, “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.3 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн, 69 дүгээр зүйлийн 69.5, 69.6, 69.7 дахь хэсгийн, 70 дугаар зүйлийн 70.2, 70.3, 70.4 дэх хэсгийн, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсгийн, 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалтын, 78.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 19.2-т заасан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.4.6 дахь заалтын “тамга /тэмдэг/” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсэг” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Даатгалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн, 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2, 54.3 дахь хэсгийн, 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсгийн, 75 дугаар зүйлийн 75.1, 75.2 дахь хэсгийн “бичгээр” гэснийг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийн “бичгээр хүссэн тохиолдолд” гэснийг тус тус хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “; эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.6, 38.7 дахь хэсгийн, 39 дүгээр зүйлийн 39.2, 39.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “; эсхүл энэ хуулийн 10.2-т заасан цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн, 43 дугаар зүйлийн 43.2.7 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “; эсхүл цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3.8 дахь заалтын “тамга /тэмдэг/” гэсний дараа “; эсхүл цахим гарын үсэг” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.3 дахь хэсгийн” гэснийг “6.2.2 дахь заалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 23
Бүгд: 41
43.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 21
Бүгд: 41
48.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
51.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Донорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалт, 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 66 дугаар зүйлийн 66.3.2, 66.3.3, 66.3.4 дэх заалт, 66.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 66.2-т заасан цахим хэлбэрээр гэж”, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн дараа “Тайлбар: Энэ хуульд заасан “гарын үсэг” гэж Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4.1.14-т заасныг ойлгоно.” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.3 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 39
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 5.5 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн, 6.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн, 6.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 10-т заасан цахим хэлбэрээр” гэж, 5.5 дугаар зүйлийн 19.3 дахь заалтын “тамга /тэмдэг/” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсэг” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 17
Бүгд: 37
54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

“3 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 3.7 дахь заалтын “тоон” гэснийг “цахим” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг,” гэснийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан системийг ашиглан цахим хэлбэрээр” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг,” “149 дүгээр зүйлийн 149.1.1 дэх заалт, 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэг,” “294 дүгээр зүйлийн 294.6 дахь хэсэг, 296 дугаар зүйлийн 296.2 дахь хэсэг,” “443 дугаар зүйлийн 443.16 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Концессын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, 18.5.3 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр”” гэснийг “18.5.3 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр”” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангаж цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “амаар болон бичгээр” гэснийг “амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “танина” гэснийг “таньж, баталгаажуулна. Тус системээр таньж, баталгаажуулсан мэдээллийг хүн, хуулийн этгээдээс цаасан хэлбэрээр шаардахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэдээлэл хариуцагч цахим хэлбэрээр бүрдүүлнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

31.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 21
Бүгд: 39
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Н.Энхболд нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

32. Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

33. Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг” гэснийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Өмгөөллийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хасуугай.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “бичгээр буюу цахим шуудангаар” гэснийг “бичгээр, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн “бичгээр” гэснийг “бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Прокурорын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан системийг ашиглан цахим хэлбэрээр” гэж, 34 дүгээр зүйлийн 34.3, 34.4 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 33.1-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-г заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтын, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3, 12.4 дэх хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, мөн зүйлийн 8.8 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа

“, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан нийтийн мэдээллийн систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 22
Бүгд: 40
45.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

43.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “заалт, 62 дугаар зүйлийн 62.5 дахь хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 14.3, 14.6 дахь хэсгийн, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн, 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.3.3 дахь заалтын, мөн зүйлийн 19.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 14.1.3-т заасан цахим хэлбэрээр” гэж, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

46. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмсүгэй:”

“4/шинжээчийн мэргэжил, албан тушаал, шинжилгээ хийсэн газар, он, сар, өдөр, хугацаа.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “54 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хугацаа бичигдсэн байна.” гэсний дараа “Шинжээчийн дүгнэлтийг цахим хэлбэрээр үйлдэх тохиолдолд цахим гарын үсгээр баталгаажуулна.” гэж,” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 2 дугаар зүйлд шилжүүлэх.”

“3/54 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Шинжээчийн дүгнэлтийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр үйлдэх бөгөөд бичгээр үйлдэх тохиолдолд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байна. Цахим хэлбэрээр үйлдэх тохиолдолд цахим гарын үсгээр баталгаажуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

48. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 35.4-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

49. Улс төрийн намын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 21
Бүгд: 40
47.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

50. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

51. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.9 дэх хэсгийн, 42 дугаар зүйлийн 42.1, 42.2 дахь хэсгийн, 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

52. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “3 дугаар зүйлийн 7 дахь хэсэг,” гэснийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

53. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

54. Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.1 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалтын, 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 24.2.1-д заасан цахим хэлбэрээр” гэж, 36 дугаар зүйлийн 36.8 дахь хэсгийн, “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

55. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн, 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсгийн, 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн, 65 дугаар зүйлийн 65.2 дахь хэсгийн, 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэсний дараах “17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг хасаж, “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 08 минут үргэлжиж, 13 цаг 15 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 03 минутад эхлэв.

57.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.2.Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр болон энэ хуульд заасан цахим хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 12.4-т заасны дагуу ирүүлсэн баримт бичиг, эсхүл Нийтийн мэдээллийн дэд бүтцээр дамжуулан хүлээж авсан мэдээллийг хэвлэн авч, мэдээллийн санд оруулснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд тооцно.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1.7 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 20.10-т заасан цахим хэлбэрээр” гэж, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “38.5.4” гэснийг “38.6.4” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.1, 10.4 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн, 40 дүгээр зүйлийн 40.3, 40.5 дахь хэсгийн, 44 дүгээр зүйлийн 44.2, 44.4 дэх хэсгийн, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийн, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн, 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсгийн, 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

61.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтын, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.5 дахь хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.4, 26.9 дэх хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 48.3 дахь хэсгийн, 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсгийн, 76 дугаар зүйлийн 76.4 дэх хэсгийн, 79 дүгээр зүйлийн 79.2 дахь хэсгийн, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсгийн, 81 дүгээр зүйлийн 81.6 дахь хэсгийн, 83 дугаар зүйлийн 83.4 дэх хэсгийн, 123 дугаар зүйлийн 123.3, 123.9 дэх хэсгийн, 132 дугаар зүйлийн 132.1 дэх хэсгийн, 148 дугаар зүйлийн 148.1, 148.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 142 дугаар зүйлийн 142.5 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

62.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай

хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 58 дугаар зүйлийн 58.6 дахь хэсгийн “дарга нь” гэсний дараа “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Цахим гарын үсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын, 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтын, 20 дугаар зүйлийн 20.3.3 дахь заалтын, 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 26.3-т заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

66.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.10 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 28 дугаар зүйлийн 28.2.7, 28.2.10 дахь заалтын, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

67.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “төлөөлүүлэгчээс бичгээр” гэсний дараа “эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр”, 56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 162 дугаар зүйлийн 162.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 180 дугаар зүйлийн 180.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 162.6-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт,” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон төсөлд нэмж тусгах:

“3 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

68.Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Шүүх шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

“2 дугаар зүйл.Шүүх шинжилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “гаргаж, гарын үсэг зурж, хувийн болон байгууллагын баталгааны тэмдгээр баталгаажуулна.” гэснийг “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулан цахим хэлбэрээр гаргана.” гэж өөрчилсүгэй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

69.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “заалт, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

70.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Гэрчилгээг цахим хэлбэрээр олгож болно.” гэснийг “Гэрчилгээний мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан авах боломжтой.” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

71.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.15 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтын “бусад техник хэрэгсэл” гэсний дараа “, эрүүл мэндийн программ хангамж” гэж, 43 дугаар зүйлийн 43.2.7 дахь заалтын “бичгээр авах” гэсний дараа “, эсхүл бичгийг цахим хэлбэрээр авах” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

72.Хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд хуулиудын хүчин төгөлдөр болох хугацааг ердийн журмаар байхаар тогтоож, холбогдох өөрчлөлтийг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 13
Бүгд: 40
67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

73.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“3 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1, 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Үндэсний цахим шилжилтийг эрчимжүүлж, нийгэм эдийн засгийн бүх салбарт мэдээллийн технологийн дэвшил, финтек, их өгөгдөл, хиймэл оюун ухааныг ашиглах боломжийг нээх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, цахим гэрээ хэлцэл хийх эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангаж ажиллах;

2/төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийхтэй холбогдсон дүрэм, журам, эрх зүйн бусад актыг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3/төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, хэмнэлттэй болгох, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, системийн уялдаа холбоог сайжруулах, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах, үндэсний мэдээллийн дэд бүтцийг хамгаалах чадавх бий болгох, энэ чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох;

4/төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хороо /Э.Батшугар/-нд даалгасугай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Хоёр.Инновац, цахим боллогын байнгын хороо дэмжээгүй санал:

1.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 38.2 дахь хэсгийн “хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 36
Бүгд: 40
10.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 31
Бүгд: 40
22.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Найруулгын санал:

Г.Занданшатар: Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, С.Одонтуяа, Х.Ганхуяг нарын Баянгол дүүргийн 25, 28 дугаар хорооны иргэдийн төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан, Х.Булгантуяа, Ж.Чинбүрэн нарын урилгаар Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Д.Сарангэрэл, Г.Амартүвшин нарын урилгаар Хан-Уул дүүргийн иргэдийн төлөөлөл, Ж.Батжаргал, Н.Энхболд, Ц.Туваан нарын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 12а, 12б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяагийн урилгаар Ховд аймгийн иргэдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 50 минут үргэлжилж, 72 гишүүнээс 53 гишүүн хүрэлцэн ирж, 73.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 07 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Гишүүдийн ирц бүрдсэн байна. Ингээд Улсын Их Хурлын намрын чуулганы 2023 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хууль тогтоолын төслийг эцэслэн батална. Нийт 30 төсөл батална. Хууль, тогтоолын төслүүд батлах учраас Их Хурлын дэд дарга нар, бүлгийн дарга нар нийт гишүүдийн олонхоор хууль эцэслэн батлах бүртгэл хангаарай.

2 дугаарт, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлнэ.

3 дугаарт, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

5 дугаарт, Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Учрал сайд аа, энэ зарчмын зөрүүтэй 93 саналтай. 93 саналаар санал хураалт явуулах учраас Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотой хууль хоорондын давхардал зөрчлийг арилгах хууль дээр бас гишүүд идэвхтэй оролцоорой.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар, Чимэдийн Хүрэлбаатар нараас албан бичиг ирсэн байна. Ингээд Сайнхүүгийн Ганбаатар. Миний бие 2023 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу зөвшөөрөл олгоно уу гэсэн байна. Ингээд энэ бичиг 15 цаг 24 минутад ирсэн байна. Ингээд дарааллаараа Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Эрхэм гишүүд ээ, сэтгүүлч Өнөрцэцэг надад захидал ирүүлсэн. Гишүүдэд та нар ч гэсэн ирүүлсэн байх. Улсын Их Хурлын гишүүний хувьд надад ирүүлсэн захидлын талаар мөн хувь хүний тухай ярих гээгүй. Зөв бурууг ярих гээгүй. Эрх баригчид МАН та нар өнөөдөр сэтгүүл зүйн салбар, сэтгүүлчдийн хэвлэн нийтлэх ажил үүргээ гүйцэтгэх мэдээ мэдээллээ гаргасантай нь холбогдуулан хууль хяналтын байгууллагад гомдол гаргаж, хууль хяналтын байгууллагаар далайлгаж, айлгаж ичээх тийм асуудал гарсан байна гэдэг энэ асуудлыг ярьсан. Энийг хэлэлцэх асуудалд оруулж ярих хэрэгтэй байна. Энийг хэлэлцэх асуудалд оруулж өгөөч ээ.

Өнөөдөр би эрх баригч нартай олон жил үзэж байна. Өрөвдмөөр шүү дээ. Аймхай, нэр хүнддээ их хайртай, арчаагүй хүмүүс. Тэгээд хууль хяналтын байгууллагуудаар далайлгаж дарамтлахлаараа бүр аюултай. Ганцаардаж муу сайныг дуудуулж явахыг би мэднэ ээ. Тэгэхлээр Өнөрцэцэгтэй холбоотой энэ асуудлыг болон 27 хууль сэтгүүл зүйн салбарын ажилтнуудын энэ асуудлаар хууль хяналтын байгууллагуудын эрх мэдэлтнүүдийн шийдвэр гаргалтын явцад хууль хэрэгжилт яаж байгаа вэ гэдэг талаар Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг баримталж Улсын Их Хурал дээр ярих цаг болсон. Яагаад гэвэл нийгэм тэр чигтээ 2 хуваагдчихаад байна. Зүгээр нэг хэдэн сэтгүүлчийн асуудал биш. Нийгэм тэр чигтээ 2 хуваагдчихаад нэлээн самуунтай байна. Нөгөө Харри Трумений хэлсэн үг байдаг шүү дээ. Өнөөдөр Сенат нийгэмд бий болж байгаа үйл самуун, эсрэгцэл талчлалыг зогсоохгүй юм бол энэ үл ойлголцол самуун дараа нь Сенатыг зогсоож, үгүй болгоно гэж нэг үг байдаг.../минут дуусав/

Г.Занданшатар: Өнөөдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр товлосон тов, асуудлын дараалал, өөрчлөлт, асуудал нэмэхтэй холбоотой горимын санал биш байна. Ингээд Чимэдийн Хүрэлбаатар гишүүн. Энэ чинь Байнгын хороогоор хэлэлцсэн асуудлууд орж ирдэг, хэлэлцэх асуудлын тов, дараалалд байхгүй асуудлууд өнөөдөр ярихгүй шүү дээ. Чимэдийн Хүрэлбаатар гишүүн.

Ч.Хүрэлбаатар: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний мэнд хүргэе. Зүгээр сүүлийн үеийн байдлыг ингээд үзээд байвал нэг бол ийм хулгай зэлгий, хөлсний хэдэн мөнгөөр хүн шантаажилдаг гэдэг. Эсвэл тэр тэрний компани хөрс хуулдаг гэнэ, ийм гэнэ, би тийм биш, чи тийм гэдэг иймэрхүү зүйлүүд нэлээд яваад байна. Ард иргэдийн хувьд бол өнөөдөр өвөлжилт ихэнх

аймгуудад нь хүндэрчихсэн, олон тулгамдсан асуудлууд байгаад байдаг. Дээр нь эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой хэдүүлээ бас арга хэмжээнүүдийг ярьдаг ийм баймаар байна.

Тэгэхээр би энэ үгийг ашиглаад 1 дүгээрт нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийг Улсын Их Хурал баталж өгөөч. Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцүүлгээ хийчихсэн. Одоо дараагийнхаа хэлэлцүүлгийг гүйцээгээд хийчихмээр байна. Эдийн засгийн өсөлт энэ ондоо 7 хувьтай гарчихаар байна. Валютын нөөц 4,3 тэрбум доллар байна. Экспорт 14 тэрбум ам.доллар-т хүрээд байна. Гарч байгаа нүүрс гэхэд чинь өнөөдрийн байдлаар 62 сая орчим тонн нүүрс бол гарчхаад байж байгаа. Тэгэхээр энэ эдийн засагтай холбоотой хууль тогтоомжийн байдлуудаа бол гаргамаар байна. Алийн болгон хулгай зэлгий, хэний компани хөрс хуулдаг вэ энээ тэрээ гэдэг ийм юм ярих юм бэ. Тийм учраас хэдүүлээ энэ эдийн засгийн асуудлууд яримаар байна.

Дараагийн нэг ярих гэсэн зүйл бол энэ ирэх жил сонгууль болно. Сонгуулийн тов тогтоох ёстой Улсын Их Хурал. Хуулийн хугацаа дуусаж байна шүү дээ. Одоо бидэнд нэг сар л үлдсэн. 2 дугаарт нь сонгуулийн тойргийн асуудлуудыг бид нар энэ дээр оруулж ирж ярина. Сонгуулийн тойро. Яг өнөөдрийн улс төрийн нөхцөл байдлаа харъя. Өчигдрийн тэр жижиг Тавантолгойтой холбоотой Өмнөговь аймагт болж байгаа зүйлүүдийг харъя. Энд тэнд нэр дэвших санаатай хүмүүс айл өрхүүдээр яваад мөнгө тараагаад эхэлчихсэн байна. Мөнгө тарааж байна. Тэгэхээр энэ тойргийн асуудал бол үндсэндээ үнэхээр чухал байгаа. Улс орны даяар авч хэрэгжүүлэх ёстой арга хэмжээнүүд аваад явбал эдийн засаг дорхноо өндийгөөд босоод ирнэ. Тойргийн жижиг ийм байдлын зовлонд яваад байх юм бол Монгол Улсын хөгжил бол хэзээ ч хөгжихгүй. Хөгжлөө ч маргааш нь нэг

нөхөр гарч ирж попроод л энэ улс орны эдийн засгийг нураана. Тийм учраас энэ сонгуулийн тойргийн асуудлыг хэдүүлээ хэлэлцэхдээ жижгэрүүлэх биш бүүр улам томруулмаар байна. Улс нэг тойрог гэж яриад явж болохгүй. Яагаад гэвэл нөгөө Үндсэн хуулийн өөрчлөлтөөр бид нар пропорциональ гээд оруулчихсан учраас улсыг нэг тойрог болгож болохгүй. Бүр нөгөө жижиг 120 хэдэн тойрог руу явахгүй зүгээр 76, 78 тойрог бол бүр болохгүй. Одоогийн тойргоо дахиад томсгомоор байна. Тухайлбал баруун аймгуудыг 1 тойрог болгочих хэрэгтэй. Тэр Увс, Ховд, Баян-Өлгийг 1 болгоод асуудлаа шийдэх хэрэгтэй. Тэгвэл тэнд эрчим хүчний асуудал нь шийдэгдэнэ. Авто замын асуудлууд нь шийдэгдэнэ. Хил боомтын асуудлууд нь шийдэгдэнэ. Тэнд томоохон хэмжээний хөрөнгө оруулалтууд орж ирэх ийм бололцоотой болно. Одоо бол танайх тийм, тэднийх тийм, чинийх бага, их гэсэн ийм асуудлууд яваад байгаа учраас сонгуулийн тойргийг тогтоохдоо бүсчилсэн хэлбэрээр хэдүүлээ явуулж байж энэ улс орны өмнө тулгамдаад байгаа эдийн засгийн асуудлуудыг бид нар шийдвэрлэж явах юм байна. Тэгэхгүй бол яг өнөөдрийн нэг ийм жалга тойрсон асуудлуудаа ярьдаг, эсвэл нэг бие бие рүүгээ дайрсан хөлс мөнгөөр нэг нэгийгээ хуссан, захиалсан ийм улс төр бол энэ Монгол Улсаас салахгүй нь. Дэлхийн улс орны геополитикийн байдлууд ч хүндрээд байгаа үед бол бид нар яах аргагүй Монгол Улс маань нэгдэж 1 болж байж, улсынхаа хэмжээнд асуудлуудаа шийддэг байж байж энэ улс орон хөгжинө.

Тэгэхээр тойрог тогтоох тухай асуудал бол дан Улсын Их Хурлын эрх мэдлийн асуудал. Тийм учраас Занданшатар дарга аа, энэ сонгуулийн хугацаа тогтоох, тов тогтоох тухай асуудал, дээр нь тойргийг тогтоох тухай асуудал дээрээ бүр ийм томруулсан байдлаар явуулах чиглэл дээр хэдүүлээ энэ улс төрийн намуудтай ярилцаж энэ асуудлаа шийдмээр байна. Ингэж байж Монгол улс хөгжинө.

Ингэж байж өнөөдөр энэ улс орон даяар яригдаад байгаа хулгай зэлгий, янз бүрийн асуудлуудын ард талд бид улсаараа гарах юм байна шүү л гэж бодож байгаа учраас энэ асуудлуудыг яаралтай хэлэлцэж эхэлмээр байна. Их Хурлын дарга аа энэ дээр та анхаарал тавьж өг.../минут дуусав/

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Бидний баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Сонгуулийн хууль баталсан. Сонгуулийн хуульд пропорциональ жагсаалтыг бол Монгол Улс нэг тойрог гэж зааж тодорхойлчихсон. Тойрог тогтоох асуудлыг бид 2 сарын 1-ний дотор шийдэх ёстой. Тэгэхдээ энийг тулгаж байгаад шийдэх биш, одоогоос хэлэлцэж эхлэх нь бол зүйтэй гэсэн Хүрэлбаатар гишүүний гаргаж байгаа санал бол зарчмын хувьд зүйтэй. Яагаад гэвэл тулгаж байгаад л гэнэт аль нэг саналаар ч юм уу шийдчих биш. Аль нэг намын эрх баригч хүчний саналаар ч шийдэгдчих биш. Ер нь бол намын бүлгүүд улс төрийн намуудын саналыг аваад Ардчилсан намын бүлгийн дарга хааччихсан. Ардчилсан намын бүлэг, парламентад суудалтай намууд энэ саналыг ярилцаад Одонтуяа гишүүн бас сонгуулийн хуульд ажигласан. Саяын энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлээд бас энэ томсгох асуудлыг судалж үзээд ер нь энэ 12 сардаа хэлэлцэхээр энэ тов тогтооё. Хүрэлбаатар сайд аа, та ч гэсэн энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг бас оруулж ирэх хэрэгтэй. Ер нь бодлоготойгоо бас уялдаад явбал бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал одоо бол дандаа нөгөө жалга дов, сум дов гэхээсээ илүү арай томоор аялал жуулчлал, уул уурхайг хөдөө аж ахуйн бодлого төлөвлөлтийг бүсчилж хөгжүүлэх хэн нэг зарчмаа оруулж ирээд бас ярьж байх нь зөв байх. Энэ тойрог тогтоох асуудлыг бол намын бүлгүүд саналаа нэгтгээд Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн дагуу

Тогтохсүрэн дарга аа энэ чинь Төрийн байгуулалтын байнгын хороо оруулж ирэх ёстой биз дээ. Сонгуулийн ерөнхий хороо санал энэ тэрийг үндэслээд, намын бүлгүүдээ үндэслээд, тэгээд намын бүлэг энэ тэрүүдээсээ саналаа аваад, энэ улс төрийн намуудаас бас санал авах ажлыг зохион байгуулаад энэ ажлаа яаравчилъя. Энэ чинь энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулахын тулд тойргоо зөв тогтоож, энийг яахгүй бол ахиад л нөгөө мөнгөний сонгууль, ахиад л авлигажсан сонгууль. Авлигалын үндэс болсон нэг жижиг асуудлууд энэ тэр гэдэг энэ юмаа нэгмөсөн том прогрессив өөрчлөлт шинэчлэлт хийх тал руу алхаж хандах нь бас зөв байж магадгүй гэж бодож байна. Ийм учраас энэ тойрог тогтоох тухай асуудлыг Нямаагийн Энхболд дарга, Тогтохсүрэн дарга, Цогтгэрэл дарга, Одонтуяа дарга, Мөнхбаатар дарга та хэд ярилцаад ойрын үед энэ хэлэлцүүлэг зохион байгуулаад, улс төрийн намуудаас саналыг нь аваад Доржханд гишүүн Тогмидын Доржханд гишүүн ингээд та хэдэд чиглэл болголоо. Засгийн газар дээр Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал оруулж ирэхийг чиглэл болголоо.

Ингээд та бүхэнд нэг бас таатай мэдээ дуулгая эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын Дээд шүүхийн шүүгч Дамдины Эрдэнэбалсүрэн Олон улсын эрүүгийн шүүхийн 2024-2033 онд ажиллах шүүгчийн сонгуульд нэр дэвшиж, сонгогдсон байна. 2023 оны 12 дугаар сарын 4-ний өдөр АНУ-ын Нью-Йорк хотноо болсон олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд оролцогч талуудын Ассамблейн 22 дугаар чуулганы хуралдаанаар нэр дэвшигч Монгол Улсын иргэн Эрдэнэбалсүрэн нийт санал өгсөн 114 улсаас 81 улсын саналыг авч сонгогдсон байна. Тэгээд энэ бол Монгол Улсын гадаад нэр хүнд өссөний бас нэг бэлгэ тэмдэг. 81 улс дэмжиж, олон улсууд өрсөлдөхөд ингэж сонгож байна гэдэг бол. Тэгээд Дамдины Эрдэнэбалсүрэн бол Монгол Улсын Дээд

шүүхийн Эрүүгийн хэргийн танхимд 10 гаруй жил эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх чиглэлээр 30 гаруй жил ажилласан манай туршилагатай шүүгч нарын нэг юм байна.

Монгол Улсын шүүгч ингэж олон улсын эрүүгийн шүүхийн шүүгчээр анх удаа сонгогдож ажиллах болж байна. Энэ бол олон улсын эрх зүй, тэр дундаа олон улсын эрүүгийн эрх зүйн үйл ажиллагаанд Монгол Улс хувь нэмрээ оруулах, Монгол Улсын шүүхийн үйл ажиллагааг бэхжүүлэх, шүүхийн нэр төрийг өргөх, цаашлаад хууль тогтоох ажиллагаанд ч гэсэн олон улсын эрүүгийн эрх зүйн туршилагыг ашиглах ийм том ач холбогдолтой юм байгаа юм. Ийм учраас олон улсын Эрүүгийн шүүхийн анхны шүүгчээр сонгогдсон Дамдины Эрдэнэбалсүрэнд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн баяр хүргэе. Улсын Их Хурлын гишүүдийн өмнөөс баяр хүргэе.

Тэгээд энэхүү ийм өндөр хариуцлагатай, ач холбогдолтой олон улсын шүүхийн шүүгчийн сонгуульд нийт 13 улс нэр дэвшиж өрсөлдсөн байна. Эхнийх нь шатын 13 улс өрсөлдсөнөөс эхнийх нь шатын санал хураалтаар л үнэмлэхүй олонхын саналыг авч Монгол Улсын иргэн сонгогдсон байна. Энэ нь бол Монгол Улсын гадаад бодлого идэвхтэй өрнөж, нэр хүнд өсөн нэмэгдэж, олон улсын хамтын нийгэмлэг манай улсад хүлээлгэж байгаа итгэл найдварын том илрэл юм. Олон улсын харилцаанд үүсээд байгаа энэ ээдрээтэй нөхцөл орчинд Монгол Улсын гадаад харилцаа урьд өмнөхөөсөө илүү эрчимтэй, илүү өргөн идэвхтэй өрнөж өндөр дээд хэмжээний айлчлалууд Монголд ирж байгаа айлчлал давтамжууд нэмэгдэж олон түүхэн үйл явдал арга хэмжээнүүд амжилттай зохион байгуулагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Монгол Улсын төрийн тэргүүн Монгол Улсын Ерөнхийлөгч бол гадаад харилцаанд Монгол Улсыг бүрэн

эрхтэй төлөөлж ажилладаг тэргүүн дипломат нь байдаг. Тэгээд үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр дипломатын аргаар хангах нь манай улсын гадаад бодлогын тэргүүлэх зорилт юм. Иймээс энэ үйл хэрэгт чухал хувь нэмэр оруулсан ажлын хэсэг байгуулж ажилласан Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, Гадаа харилцааны яам, НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газар, холбогдох бусад байгууллага, хүмүүст баяр хүргэж, талархал илэрхийлье.

Манай Хүрэлбаатар сайдын хэлснээр дандаа сөрөг муу юм ярьж байхар бас энэ олон улсад ч гэсэн болж байгаа энэ сайн онцлог үйл явдлын нэгийг ч гэсэн тэмдэглэж хэлье.

Ингээд хууль, тогтоолын төсөл эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д 7 хоногийн баасан гаргийн 10 цагаас нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийг эцэслэн батална гэж заасан. Мөн хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн баталж санал хураалт явуулж болно гэж заасан. Ингээд Байнгын хороод бол энэ хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах хувилбарыг бэлтгэж, гишүүдэд тарааж, эцэслэн батлуулах бэлтгэл хангасан байгаа. Одоо төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя. Э нэ хуулийн төслүүдийг хэлэлцэн батлахгүй бол бас энэ орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөв санхүүгээ батлах гээд байдаг, батлаад байдаг, тэгээд энэ хууль маань үйлчилж эхлэх хэрэгтэй байгаа. Одоогийн явж байгаа бас олон асуудлууд ч гэсэн энэ Эрүүгийн хуультай бас холбоотой байгаа. Тийм учраас нийт ирц 44 байна. Ингээд бүгд бүрдсэн байна. Эхлээд бүртгэлийн санал хураалт явуулна. Бүртгэлд ороогүй гишүүдийг өнөөдрийн

чуулганыг тасалсанд тооцно. Санал хураалт. Бүртгэлийн санал хураалт, туршилтын санал хураалтыг нэг мөр явуулъя.

Бейсен, Гочоогийн Ганболд, Идэрбат, Саранчимэг, Цогтгэрэл, Саранчимэг байхгүй. Тамгын газар энэ Бейсен, Адьяасүрэн 2 гишүүн ажиллахгүй байна гэж байна. Энэ юуг нь Идэрбат 3 гишүүн. Гочоогийн Ганболд гишүүн хааччихав. Сонсголоо удирдаж байгаа юу. Ганболд гишүүн бол хүндэтгэн үзэх шалтгаантай, сонсгол давхацсан байна. Санал хураалт явуулах уу.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 39 гишүүн дэмжиж Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт орох тухай хуулийн төслийг эцэслэн баталлаа.

Дагаж боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Ярихгүй шүү. 39 гишүүн нэмж хууль эцэслэн батлагдлаа. Хүрэлбаатарын Булгантуяа, Тогмидын Доржханд 3 байгаа мөртөө эсрэг болоод байна. Доржханд гишүүн ээ, энэ чинь хүүхдийн хүчирхийлэл энэ тэртэй холбоотой. Тэгээд та чинь бас үг хэлж байсан хүн шүү дээ.

3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 41 гишүүн дэмжиж хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж 93,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Буланы Бейсен гишүүний үг хэлнэ ээ.

Б.Бейсен: Би дэмжээд санал өгсөн боловч энэ төхөөрөмж ажиллаагүй учраас дахин санал хураалгаж өгнө үү.

Г.Занданшатар: Төхөөрөмж ажиллаагүй учраас, төхөөрөмж бас хугацаа нь дуусчхаад ингээд байгаа юм. Ер нь гар өргөөд баталчих уу. Тийм горимын саналаар санал хураалт явуулж болно. Бейсен гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт. 90,9 хувийн саналаар өмнөх саналыг хүчингүйд тооцлоо. Дэлгэрсайхан гишүүн яасан яасан гэнэ э. Саяны санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя. 41 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

2.Хамт өргөн мэдүүлсэн:

Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Сайнхүүгийн Ганбаатар гишүүнийх орохгүй байна гэж байна. Тэгээд орсонд тооцъё гэж байгаа. Санал өөрөө гаргасныг уламжилъя.

6.Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 39 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Тогтохсүрэн дарга, Раднаасэд дарга 2 саналаа өгөөрэй. Ганбаатар гишүүнийх бол бас нөгөө санал нь ороод байна. Одоо бол орж байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Нийслэл Улаанбаатар хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор

санал хураалт. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

13. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Энэ хуулийг чинь буцаая гэж тохирсон чинь яагаад ороод ирэв. Энэ нөгөө Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг. Тэр чинь нөгөө үндсэндээ нөгөө заалтуудыг нь хасчихсан шүү дээ тээ. Засчихсан. Тэгээд засчихсан чинь үндсэндээ хуучин хуулиараа үлдээж байгаа учраас энэ хуулийг чинь буцаачих нь зүйтэй юм байна гэж. Санал хураалт явуулъя. Эцэслэн батлах санал хураалт. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

14. Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Раднаасэд гишүүн саналаа. 42 гишүүн дэмжиж, хуулийн төсөл батлагдлаа.

15. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 41 гишүүн дэмжиж, эцэслэн батлагдлаа.

17. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

19. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, эцэслэн батлагдлаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хуулийн эцэслэн батлагдлаа.

25. “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжи, 87 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Хууль тогтоолын төслүүд эцэслэн батлагдлаа.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Тэгээд Улаанбаатар хотын түгжрэлийг тэгээд л бууруулаад л байж дээ.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

10.43 цаг.

Дараагийн асуудалд орно.
Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Дараа нь 93 саналтай нөгөө Цахим шилжилтийн тухай хууль байгаа.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 3 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн батлан хамгаалах салбарын мэргэжлийн цэргийн бүрэлдэхүүнд алба хааж байгаа эмэгтэй цэргийн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх боломжийн талаар асуулт асууж хариулт авлаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ж.Чинбүрэн, Ц.Сандаг-Очир нараас дотоодын цэргийн албан хаагчдын эрүүл

мэндийн үзлэгийг зөвхөн цэрэг татлагын үеэр бус алба хаах хугацаанд тогтмол хийх, цэргүүдэд бие бялдар, сэтгэл зүй, ур чадвар, мэргэжил олгох сургалтыг зохион байгуулахад онцгой анхаарах талаар санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг, Салдангийн Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 25, 28 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт Баянголчууд та бүхэндээ ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Ер нь Ганбаатар гишүүн ээ, дүүргийг хот болгоод, хороог дүүрэг болгочихмоор байгаа юм даа. Хотыг нийслэл болгоод л тэгээд л ингэж байж л төвлөрөл саарах юм байна лээ. Тэгээд орон нутагт эрх мэдлийг нь өгөөд.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Батлан хамгаалахын дэд сайд Батсүхийн Баярмагнай, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал Сүнрэвийн Ганбямба, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Чулуунборын Гандирваа, Батлан хамгаалах яамны Хуулийн хэлтсийн дарга Гомбосүрэнгийн Энхболд.

Энэ эцсийн хэлэлцүүлэг байгаа. Тэгээд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Буланы Бейсен гишүүнээр тасаллаа. Буланы Бейсен гишүүн асуулт асууна.

Б.Бейсен: Энэ хилийн цэрэгт заставууд дээр ажиллаж байгаа албан хаагчдын гэр бүлийн асуудал байгаа. Дээд боловсролтой, дунд боловсролтой хүмүүс оччихоод ямар ч ажилгүй байдаг. Энд Засаг дарга нартай гэрээ хийдэггүй 1 дүгээрт. Сум дээр ажиллах аймгийн төвд ажиллах хүмүүс байж байдаг. Дээд мэргэжлийн хүмүүс оччихоод ажилгүй байж байдаг. Энийг нь Нийгмийн даатгалын шимтгэлийг Хил хамгаалах газар, Батлан хамгаалах яамнаас хийж өгдөг үү. Эд нар чинь тэтгэвэр, тэтгэмжээр хохирч байгаа асуудлууд байж байгаа. Энийг яаж шийдэж байгаа юм бол. Нөгөө талаар сургуулийн насны хүүхдүүдээ сургах гээд аймгийн төв юм уу, сумын төвд нөгөө албан хаагчдын гэр бүл нь ажиллахаар болдог. Гэтэл орон тоо байдаггүй. Орон тооны асуудлыг тэр Засаг дарга нартай гэрээ хийж байж шийдэх үү. Ер нь энэ талаар тусгасан юм байна уу.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцсэн байх биш. Энэ чинь Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцсэн. Анужин гишүүн хаана байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн чинь сая сонсголд явчихсан. Батлан хамгаалахын дэд сайд Баярмагнай хариулъя. 82. Батсүхийн Баярмагнай.

Б.Баярмагнай: Эрхэм гишүүд, Их Хурлын даргад энэ өглөөний мэндийг хүргэе. Тэгэхлээр хилийн цэрэг бол манай Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллага ерөнхийдөө бол Хууль зүйн яам, салбарын сайд нар маань орон нутгийн засаг захиргаатай бол оны эхээр үр дүнгийн гэрээ байгуулдаг. Энэ гэрээндээ ажлын байраар хангах

асуудлыг бол тухайн аймгийнхаа орон нутгийн удирдлагуудтай гэрээ байгуулах замаар ажлын байраар хангах үүргийг орон нутаг хүлээж, зохицуулалт хийж болдог. Тэгээд тэр хүрээндээ бол Хууль зүйн сайдтай хийх үр дүнгийн гэрээний хүрээнд бол ирэх оны эхээр хийгдэх гэрээнд бас суулгаж өгч болох байх гэж бодож байна.

Г.Занданишатар: Буланы Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Сая асуусан шүү дээ. Би тэр хил застав дээр ажиллаж байгаа цэргийн албан хаагчдын гэр бүл нь төсөвт байгууллагуудын юм уу юунд ажиллаж байгаад нөхрүүдээ дагаад оччихоод ажилгүй тэгээд нийгмийн даатгалын шимтгэл нь тасарчихдаг байхгүй юу. Энийг хил хамгаалах байгууллага нөхөж төлж өгдөг үү. Тэгэхгүй бол бас тэтгэвэр тэтгэмж авахаасаа бас хохирч байгаа асуудлууд байж байгаа байхгүй юу. Энэ энийг яаж шийдэж байгаа юм.

Г.Занданишатар: Ганбямба генерал хариулах уу. Ганбямба генерал 83 хариулъя. Сүнрэвийн Ганбямба.

С.Ганбямба: Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал Ганбямба илтгэж байна. Энэ хилийн отряд заставт ажиллаж байгаа алба хаагчдын маань гэр бүл бас яг тэр тухайн орчин нөхцөлтэйгөө уялдуулаад ажлын байраар бүрэн хангагдаж чадахгүй байгаа. Тэгээд яг өнөөдрийн хэлэлцүүлж байгаа хууль маань бол зөвхөн цэргийн албан хаагчидтай холбоотой тэтгэвэр, тэтгэмжийн хууль байгаа. Тэгэхээр энэ асуудлыг Хил хамгаалах ерөнхий газар, Хууль зүйн яаманд бас асуудал дэвшүүлж холбогдох. Тухайлах юм бол Улсын хилийн тухай хуульд тэр хилчдийн эрх зүйн байдал бас хамаарсан зүйл заалтууд байгаа. Энэ дээр нь гэр бүлийн асуудал гэдэг байдлаар тусгаж эрх зүйн чадамжийг нь

дээшлүүлэх боломжтой болов уу гэсэн хариулт өгье. Хариулж дууслаа.

Г.Занданишатар: Ер нь энэ хилийн заставын нэн ялангуяа алслагдсан бүс нутгуудад, говийн бүс нутагт алба хааж байгаа хилийн заставын офицер ахлагч нарын ар гэрийнхний ажил эрхлэлтийн байдал, нийгмийн даатгал шимтгэлийн төлөлтийн байдал бас хүндрэлтэй байдаг. Энийг нэг бас анхаарч шийдэхээр хилээ хамгаалж байгаа цэрэг эрсийн гэр бүлийн асуудлыг анхаарах шаардлагатай гээд заставуудаар ажиллаж байхад Баян-Өлгий аймагт ажиллаж байхад нэн ялангуяа олон газар яригддаг юм. Нэн ялангуяа говийн аймгуудаар ч гэсэн алслагдмал. Энийг бас нийгмийн даатгалын шимтгэл төлөх эрх зүйн орчин, тэнд ажил эрхлэлт, заставын орон тоо, гэрээт орон тоо энэ тэрийг гаргаж хангуулах боломжийг бол судалж үзэх ёстой юм байна лээ шүү. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна. Ажлын хэсэгт баярлалаа.

10.51 цаг.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Батсуурь: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбарын төсөл эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан, Хүрэлбаатарын Булгантуяа, Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарын урилгаар Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн

төвийн эмч нарын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ингээд эрхэм хүндэт эмч нар, эрүүл энхийг хамгаалах ажилтнууддаа хүн ардынхаа эрүүл энхийн төлөө зүтгэх ариун үйлсэд нь өндөр амжилтыг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Сайн сайхныг хүсье.

Ажлын хэсгийг танилцуулъя. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Дангаагийн Баярболд, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Пүрэвийн Оюунцэцэг нар байна. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Тасаллаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

10.54 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Батсуурь: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Занданиатар: Ажлын хэсгийг танилцуулъя. Зоригтын Мөнх-Оргил Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ганбаатарын Энхтүвшин Эрчим хүчний яамны Стратеги төлөвлөлтийн газрын дарга, Баяртогтохын Нямсүрэн Эрчим хүчний яамны Гэрээ, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Энэ тогтоолын төсөл чинь хуультайгаа хамт батлагдах байж байгаад бас зарим нэг гишүүнээс санал гомдол гаргаад хойшлуулчихсан юм аа тээ. Хуультайгаа

хамт батлагдах ёстой байсан тогтоол шүү дээ.

Энэ чинь нэг уурын зуухны асуудлууд байгаа. Тэрнийхээ хэрэгжилтийг аймаг сумд нөлөөлөх юмыг хуулийнхаа хэрэгжилтийг сайн анхаарч ажиллаарай. Тэгээд эргэж тайлан өгөөрэй.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Төсвийн байнгын хорооны дарга, энэ дээр ямар нэгэн асуудал байхгүй тээ. Чойжилсүрэн сайд өөрөө хаачсан юм. Сайд байхгүй бол хойшлуулах дүртэй л дээ. Гишүүд хаана байна. “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Гишүүд орж ирээрэй. Үүдэнд байгаа гишүүд орж ирээрэй. Балжиннямын Баярсайхан гишүүнийг суунгуут санал хураалт эхэлнэ. Санал хураалт. Батсуурь гишүүн дарсан. Баярсайхан гишүүн дараагүй юм байна. Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Дарга аа, төхөөрөмж ажиллаагүй тул санал хураалтыг дахин явуулж өгнө үү. Хүчингүй болгоод дахин явуулж өгнө үү.

Г.Занданиатар: Санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжиж, өмнөх саналыг хүчингүйд тооцлоо. Өмнөх саналыг хүчингүйд тооцсон учраас дахин санал хураалт явуулна. Санал хураалт. 56,4 хувийн саналаар санал дэмжигдэж, тогтоолын төсөл батлагдлаа. Сайд нарт анхааруулахад Дэлгэрсайхан сайд, Засгийн газрын гишүүд танхимын зарчмаар ажиллана шүү. Өөрийнхөө хуулийг батлахаар баталчхаад л, тэгээд бусад сайдууд өөр юм болохоор гараад

явчихдаг . Засгийн газрынхаа хуулийг ингээд батлах болохоор гараад явчихдаг байж таарахгүй.

11.00 цагт.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Инновац цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн танилцуулна. Чинбүрэн гишүүн хаачсан. Батишугар. Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батишугар танилцуулна. Индэрт урьж байна. Энэ Чинбүрэн гишүүнийг дуудаарай. Өглөө карта хийчхээд, тэгээд ирцэд орчхоод алга болчхоод байж таарахгүй шүү.

Э.Батишугар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг 2023 оны 6 дугаар сарын 9, 15-ны өдрүүдэд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хэлэлцүүлгийн явцад хуралдааны даргалагчаас дээрх

хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац цахим бодлогын байнгын хороо, Хууль зүйн байнгын хороонд тус тус шилжүүлсэн билээ.

Инновац цахим бодлогын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 3 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэнээр ахлуулсан Улсын Их Хурлын гишүүн Батишугар, Ганибал, Идэрбат, Саранчимэг нарын бүрэлдэхүүнтэйгээр хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулахаар ажилласан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт Инновац цахим бодлогын байнгын хороонд ирүүлсэн.

Байнгын хороогоор 2023 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхан хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дахь хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх явцад Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүд дээр бичгээр гэсний дараа эсвэл цахим хэлбэрээр гэж нийтлэг байдлаар тусгахаар оруулж байгаа өөрчлөлт нь тухайн хуулиар зохицуулсан харилцаанаас хэт өргөн агуулгаар тусгасан нь цаашид хууль хэрэглээний явцад тодорхой нөхцөл байдал бий болох тул төрийн байгууллага хооронд болон төрийн байгууллагаас хүн, хуулийн этгээдтэй, хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллагатай иргэн хоорондын харилцааг тус бүрээр нь ангилж холбогдох өөрчлөлтүүдийг тусгалаа.

Тухайлбал, төрийн байгууллага, албан тушаалтан нь хоорондоо цахим хэлбэрээр мэдээлэл солилцох харилцааг Нийтийн мэдээлэл ил тод байдлын тухай хуультай нийцүүлэн тус хуулийн 18.2-т заасан нийтийн мэдээллийн систем болон албаны цахим шуудангаар ашиглах, хүн хуулийн этгээдээс төрийн байгууллагын албан тушаалтантай харилцах харилцаанд нийтийн мэдээлэл ил тод байдлын тухай хуульд заасан системүүд болон эрх зүйн үр дагавраас хамаарч иргэний хууль болон цахим гарын үсгийн тухай хуульд заасан цахим гарын үсэг тоон гарын үсгийг тус тус хэрэглэхээр, мөн эрх эрх зүйн үр дагавар багатай эсвэл тухайн салбарын хууль, тогтоомжоор баталгааждаг болон хуульд амаар гүйцэтгэж болохоор тусгасан харилцаанд аливаа хэлбэрээр заахгүй байх зэрэг өөрчлөлтүүдийг тусгасан.

Ажлын хэсгийн хуралдаанаар хуралдаанаар дэмжсэн 43 хуулийн төслийн 52 зарчмын зөрүүтэй саналын томъёолол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар гаргасан 2 зарчмын зөрүүтэй, саналын томъёолол, найруулгын 1 санал тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд дэмжсэн нийт 28 хуулийн төслийн 36 зарчмын зөрүүтэй саналын томъёолол гарсныг Инновац

цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн. Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 38.2 дахь хэсгийг цахим баримт бичиг нь цаасан баримт бичигтэй адил хүчинтэй байх бөгөөд зөрсөн тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол анх баталгаажсан баримт бичгийн хэлбэрээр, цаашид баримт бичгийн эх хувийг баримтална гэж заасан нь хуульд өөрөөр заагаагүй бол гэснийг хасах. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийг өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй санал тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжээгүй.

Байнгын хорооны хуралдаанаар зарчмын зөрүүтэй саналын томъёололыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн үйлчилгээ цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Инновац цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийг танилцуулъя. Цахим хөгжил, харилцаа

холбооны сайдын зөвлөх Сүхээгийн Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Бадамдоржийн Билэгдэмбэрэл, Содовжамцын Цагаанхүү Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлье. Бямбацогт гишүүнээр тасаллаа. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулаад хэд хэдэн асуудлуудыг тодруулж асууя. Төрийн үйлчилгээ цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хуулийн хийдэл болоод давхардал, зөрчлийг арилгах зорилгоор бас хэд хэдэн өөрчлөлтүүд Засгийн газраас санаачлаад, Байнгын хорооны энийг нь бас ажиллаад ингээд орж ирж байгаа юм байна. Тэгэхээр бид бүхний хувьд хүндрэлтэй нэг ийм асуудлууд үүсээд байгаа юм. Сая Үндэсний аудитын газраас уул уурхайн орлоготой холбоотойгоор Татварын ерөнхий газар болоод Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмал газрын тосны газартай холбоотой нэг тодорхой дүгнэлт гарсан байсан. Энэ бол асуудал нь өөрөө юу вэ гэхээр төрийн байгууллага хоорондын нөгөө датагаа нэгтгэх, хоорондоо мэдээлэл солилцох асуудлууд бол хамгийн хүндрэлтэй асуудлууд болчихсон байна. Уг нь бид нар Засгийн газраас цахим шинж гэдэг асуудлыг яриад байдаг. Мэдээллийн нэгдсэн сан үүсэх асуудлууд өөрөө бодит амьдрал дээр бас хэрэгжиж өгдөггүй. Биг дата үүсгэх асуудлууд байдаггүй. Зөвхөн нэг тоон мэдээллийг аваад үзэхээр Монгол Улсын хилээр гарсан нүүрсний ачилттай холбоотой, тээвэрлэлттэй холбоотой мэдээлэл гэхэд 3 газар Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Ашигт

малтмал, газрын тосны газрын 3 мэдээлэл хоорондоо 3 өөр зөрж байгаа юм. Сая саяар хоорондоо зөрж байгаа асуудал гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэн дээр бид нар энэ аудитын дүгнэлт гарсан энэ асуудлууд дээр ер нь цаашидаа энэ хийдлийг арилгах тал дээр ер нь яах ёстой юм бэ. Та бүхэн энэ төрийн байгууллага хоорондоо мэдээллээ нээлттэй солилцдог байх, төрийн нэгдсэн биг дата үүсгэх асуудлууд дээр энэ зөрчлийг нь арилгаж чадсан юм уу. Хийдэл хоорондоо байгааг нь гэдэг юм уу эсвэл хоорондоо мэдээллээ солилцохыг хүсэхгүй байгаа асуудлуудыг хүчээр зохицуулах энэ зохицуулалтуудыг хийсэн юм болов уу. Тэгэхээр одоо Монгол Улсад төрийн үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллагууд одоогийн байдлаар яг хэдэн систем хөгжүүлээд, хэр их зардал төсвөөс гараад байгаа юм. Уг нь байгууллага болгон хоорондоо тус тусдаа 1, 1 нэгдсэн систем байх ёсгүй. Яам дотор газар дотроо хүртэл бараг тус тусдаа системтэй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг уг нь зардал хэмнэх үүднээсээ ч гэсэн, төрийн ажил үйлчилгээг шуурхай явуулах үүднээсээ ч гэсэн, бүх мэдээллийг нэгтгэх үүднээсээ бид нар нэг том биг дата үүсгээд, нэг зардлаар уг нь шийддэг байх зайлигүй шаардлагатай байгаад байгаа юм. Гэтэл яам болгон тус тусдаа, агентлаг болгон тус тусдаа өөрсдөө мэдээллийн нэгдсэн сантай байдаг. Одоо сүүлдээ яам дотроо газар болгон дотроо тус тусдаа системтэй байдаг асуудлууд гарч ирчхээд байгаа байхгүй юу. Тэгээд бид нар цахим шилжилтийн асуудлуудыг яриад байдаг. Энэ дээр мэдээллүүдийг нэгтгэх тал дээр ер нь анхаарч чадаж байна уу, үгүй юү. Энэ хуулиар бүх мэдээллүүдийг нэгтгэх тал дээр зохицуулалтыг хийж чадаж байгаа юу, үгүй юу.

Мэдээллийг олон нийт болоод төрийн байгууллага төрийн бус байгууллагууд мэдээллээ хэрхэн харилцан солилцож байх ёстой юм бэ. Жишээ нь нэг асуудал үүсэж байгаа юм. Нэг

төрийн захиргааны байгууллага захиалга өгөөд магадгүй судлаач нараар судалгаа хийлгүүлээд модель үүсгэж байгааад ингээд мэдээлэл нэгтгэх гэхээр тухайн тэр төрийн байгууллагын захиалгаар хий хийлгэсэн зөвлөх үйлчилгээгээр хийлгэсэн тухайн тэрмэдээ шаардлагатай мэдээллүүдийг нэгтгэе гэхээр манайх энэ хориглолтой асуудлууд байна. Манайх мэдээллээ өгөхгүй. Хувь хүний нууцлалтай холбоотой асуудлууд гэдэг асуудал байдаг. Тэгэхээр энийг яах ёстой бол. Мэдээллээ ер нь хэн хариуцах вэ. Статистик эцэслэх үү эсвэл хувь хүний нууцын мэдээллийг танигдахгүйгээр хэрхэн хоорондоо мэдээлэл солилцож тэрийг нь биг датадаа ашиглаж, цаашид төр шийдвэр гаргахдаа энэ судалгаан дээрээ суурилсан, мэдээлэл дээрээ суурилсан шийдвэрүүдийг гаргадаг байхад ашигладаг байх зайлиггүй шаардлагатай байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр цаг хугацааны хувьд бид нар энэ хийдлийг хэзээ ялгаж болох ёстой бол. Энэ хуулиудын өөрчлөлтийн хүрээнд хийх боломж байгаа юу гэдэг асуудал байгаад байгаа юм. Уг нь магадгүй нэг хууль дээр нэг заалтаар ч гэдэг юм уу эд нар энийг зохицуулах боломжтой тэр хуулийг нь даргаас чиглэл аваад, дахин боловсруулах ч гэдэг юм уу ингээд нэг ажиллаад үзвэл яасан юм бэ гэсэн бодол байгаад байгаа юм. Бид нар дөнгөж саяхан 7 хоногийн өмнө үүссэн асуудал байгаа юм. Аудитын дүгнэлт ингэж гарсан, дээрээс нь яг бодит амьдрал дээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа аж ААН, байгууллагууд энэ 3, 4 байгууллагын мэдээллийг нэгтгэе тэгэхээр болохгүй гэдэг асуудлууд яриад байгаа юм. Одоогийн хуулийн хүрээнд.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал Цахим хөгжил, харилцаа холбооны сайд хариулъя.

Н.Учрал: Тэмүүлэн гишүүн маш чухал асуудлыг бас хөндөж байгаа. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулиар суурь болон төрөлжсөн мэдээллийн сантай давхардуулан

мэдээллийн сан үүсгэхийг хориглоно гээд зачихсан. Бие даасан мэдээллийн сан үүсгэхийг хуулиар хориглочихсон байгаа ч гэсэн энэ олон байгууллагууд дур дураараа мэдээллийн сан үүсгэсээр байгаад хоорондоо холбогдохоо больчихсон байгаа. Тэгээд сая Засгийн газраас яг энэ нээлттэй мэдээллийн сан, нээлттэй өгөгдлийн санг үүсгэх Засгийн газрын шийдвэр гарсан. Үүнийг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Үндэсний статистикийн хороо хамтарч хэрэгжүүлж байгаа. Ингээд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны тусламжтайгаар бид нар энэ нээлттэй өгөгдлийн сангийн 606 жагсаалт гаргасан. Нээлттэй мэдээллийн сангаа энэ 120 хуулийг дагуулаад хуульчилж байгаа юм. Юу гэж хуульчилж байгаа вэ гэхээр өнгөрсөн хугацаанд бид нар 950 мянган мөр өгөгдөл боловсруулаад, нээлттэй мэдээллийн 68 мэдээллийг нэгтгээд shilen.gov.mn дээр нэгтгэсэн. Үүнийг анх удаа Нээлттэй мэдээллийн сан гэж хуульчилж өгч байгаа. Тэгэхээр төрийн бүх байгууллагууд shilen.gov.mn нээлттэй мэдээллийн сан дээр мэдээллийг байршуулах үүргээ хуулиар хүлээгээд Зөрчлийн хуулийг дагуулж өөрчлөлт оруулж байгаа юм. Хариуцлага хүлээлгэж байгаа. Нээлттэй өгөгдөл бол нөгөө боловсруулагдаагүй мэдээллүүд буюу биг дата. Тэр биг датаг бид нар шийдвэр гаргалтад ашиглах чиглэлээр нийт 606 биг датаг жагсаалтыг нь батлаад, open data дээр нэгтгээд, төрийн байгууллагуудыг шахаад явж байгаа. Энэ хуулиар бид нар тухайн төрийн байгууллагуудад бие даасан мэдээллийн сан үүсгэхгүй шүү. Энэ өгөгдлүүдийгээ энэ биг дата дээр нэгтгэе гэдгийг хуулиар бас үүрэг болгож байгаагаараа давуу талтай.

Дээрээс нь Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийг эргэж харахгүй бол болохоо больчихжээ. Яагаад вэ гэхээр ерөөсөө манайд ямар хэлбэрээр анх архивлагдсан бэ гэдгээр нь архивлахгүйгээр цахимаар архивлагдаж байсан материалуудыг цаасаар хэвлээд

давхар сейфэнд хадгалаад бай гээд ингээд шахаад байдаг. Өнөөдөр яг энэ өдрүүдэд энэ нүүрсний сонсгол явагдаж байна л даа. Сая тэр нүүрсний сонсгол дээр жишээ нь тэр ТУЗ-ийн даргыг анх томилсон шийдвэр олохгүй байна шүү дээ тэр нөхдүүд. Тэгээд анх цахимаар энэ шийдвэр боловсруулагдсан. Тэгээд энийг хэвлэж хадгалаагүй гээд нэг ийм хачин юм яриад суугаад байгаа байхгүй юу. Яг үнэндээ Архив, албан хөтлөлтийн хуулийг нь эргэж харж энийг янзлахгүй бол өнөөдөр анх цахимаар боловсруулагдсан тэр архивын мэдээлэл нь цаасаар хэвлэгдээгүйгээсээ болоод ийм давхар ажил хийгдээд нэг ийм байдалтай болчихсон. Тэгэхээр Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль дээр цахимаар архивлах буюу өдөр тутмын тэр мэдээлэл солилцох бичгүүдийг цахимаар анх үүсгэсэн бол харилцаад яв, заавал түүнийг нь хэвлээд хадгалах шаардлага байхгүй. Заавал хэвлэж хадгалах буюу ийм цаасан хэлбэрээр байх ёстой архивын жагсаалт нь юу юу юм бэ гэдгийг бүгдийг нь ингэж ангилж өгсөн. Ингээд энэ салбар дундын зохицуулалтуудыг буюу салбарын хуулиудыг нь бид нар өөрчилж, цахим хэлбэрээр байж болох юм уу гэдгийг нь хуульчилж өгөхгүй бол яг цаашидаа бол цахимжилт хурдална гэвэл маш цаг хугацааг алдах юм билээ. Яагаад гэхээр өнөөдөр нийтийн мэдээллийн дэд бүтэц гэж нэрлэгдээд байгаа нөгөө хураар байна уу, энэ и-монгол дээр байна уу төрд байгаа мэдээллүүд нь байгаад байдаг. Эргээд эцэстээ нөгөө хүмүүсээсээ иргэдээсээ цаасаар нэхээд байгаа чинь салбарын хуулиудаар цаасаар гээд нэхчихсэн юм чинь, бичгээр гээд нэхчихсэн юм чинь төр өөрөө батлагдсан хуулийг хэрэгжүүлэх л ёстой шүү дээ төрийн байгууллагууд. Тэгэхээр үүнийг нь өөрчлөхгүйгээр эргээд төрийн байгууллагууд ч бай, төрийн бусууд ч бай та нар хоорондоо цахимаар бичиг солилц, хүнд сурталгүй бай гэж хэлэх гэхээр хуулиа л хэрэгжүүлж байна гэдэг ийм юм яриад байдаг. Тэгэхээр энэ хууль хэрвээ батлагдан гарах юм бол энэ олон

замбараагүй мэдээллийн сангууд цэгцрэх ийм бол.../минут дуусав/

Г.Занданиатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд, Даваажанцангийн Сарангэрэл, Ганибалын Амартүвшин нарын урилгаар Хан-Уул дүүргийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе.

Ажлын хэсгээс нэмж, тодруулж хариулах хүн байна уу. Чинбүрэн гишүүн танилцуулах үед өөрөө алга байсан, танилцуулаагүй л дээ. Хамгийн гол нь энэ тэр гааль, татварын санхүүгийн мэдээллийн төвийн хувийн мэдээлэл, хувийн мэдээллийн нууцын тухай хуулиар хамгаалагдаад байгаа. Хамгаалагдах ч юу байх вэ. Нийтийн мэдээлэл болгож тэрнийг хувиргаад, нийтийн мэдээллийн санд оруулах дээр биг дата болгож ашиглах үндэсний дата товчоо байгуулаад дата буюу их өгөгдлийг нэгтгэх, шэйр буюу хуваалцах, хөгжүүлэх. Тэгээд машин, хиймэл оюун ухаан ашиглаад ингээд дүгнэлт энэ тэр гаргах ийм ажлуудыг энэ эрх зүйн орчин энүүгээрээ бүртгэх үү гэдгийг асуугаад байна шүү дээ. Зарим хүн чинь хувийн мэдээллийн нууцын хууль дээр болохоор Гааль санхүүгийн мэдээллийн төв, Нөатын мэдээлэл энэ тэр чинь ингээд хувь хүн биш хувиргаад, кодлоод хувь хүний мэдээллийг нь дараад хийчхэж болох юмыг хуулиар болохгүй гээд л хориглолцоод гагцхиаад байгаа юм л даа. Одоо бид нар ингээд дата том анализыг хийлгэж байна. Татварын орчин дээр. Тэгтэл энэ дээр бүгд болдоггүй. Энэ асуудлыг асуугаад байгаа шүү дээ Чинбүрэн гишүүн ээ. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн. Энүүгээр нээлттэй болох юм уу, Үндэсний дата товчоо байгуулагдах уу.

Ж.Чинбүрэн: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Ер нь бол энэ цахим

хөгжилтэй холбоотой бид энэ хууль давхцалын асуудал дээр нийтдээ Засгийн газраас өргөн барьсан хууль бол 435 хуульд нийцлийг шалгаж үзсэн байдаг. Тэгэхээр энэ хуулийн гол зорилго бол ерөөсөө л энэ давхцал. Ер нь бол цахим хэлбэрээр мэдээллийг төр иргэнтэйгээ, хуулийн этгээд төртэйгөө, төр төртэйгөө хэрхэн хоорондоо харилцаж мэдээллээ солилцож байх вэ гэдэг л гол ийм үндсэн давхцалыг арилгах зорилготой ийм хууль давхцалыг арилгах ийм хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд орж байгаа. Тэгээд энэ 435 хуулиас 140 гаруй хууль нь бичгээр, биеэр, тамгаар хүргүүлнэ гэсэн заалтуудыг илүү цахимжуулж, давхцалыг арилгах зорилготой ийм өөрчлөлтүүд орсон.

Тэгээд таны асууж байгаа зүйл дээр бол ер нь хамгийн гол асуудал бол энэ төрийн байгууллагууд хоорондоо албан тушаалтнууд цахим хэлбэрээр харилцах харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай нийцүүлэн тус хуулийн 18.2-т заасан нийтийн мэдээллийн систем болон албаны цахим шуудан ашиглан тодруулж асуух мэдээлэл солилцох ийм боломжийг бүрдүүлж өгч байгаа. Яг энэ давхцалтай холбоотой энэ хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой бол ямар нэгэн мэдээллийн сангуудыг тухайн салбар бүр өөрөө хэрхэн ашиглах талаар заалт бол тусгайлан ороогүй. Энэ илүү төр иргэн, төр хуулийн этгээдүүдийн хоорондын харилцаан дээр давхцал хийдлийг арилгах.

Харин энэ дээр бол орсон нэг чухал Их Хурлаас гарч байгаа тогтоол хуультай холбоотой гарч байгаа тогтоол дотор бол Эрүүл мэндийн салбарын мэдээллийн сангийн тухай бол онцгойлон дурдсан. Тухайлах юм бол эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн сан, дээрээс нь магадлал олгодог. 10 гаруй магадлан өгдөг иргэнд. Тухайлах юм бол эрүүл мэндийн байдал, группт орсон байдал, өвчтэй байсан гэдэг ч гэдэг юм уу энэ магадлан мэдээллийн сантай болгоод үүнийг бусад төрийн

байгууллагууд албан ажилтнуудад мэдээллийг нь шуурхай өгч хүргэх энэ боломжийг бүрдүүлэх чиглэлд Цахим хөгжлийн яам, Эрүүл мэндийн яам хамтарч ажиллах ийм тогтоолд үүрэг даалгавар өгч оруулж байгаа.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн Төсвийн байнгын хорооны дарга асууя.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр яг одоогийн энэ хуулийн өөрчлөлтийн хүрээнд болохгүй юм байна. Бид хэд гол сонирхоод байгаа зүйл бол ерөөсөө хувь хүний нууцын мэдээллийг ерөөсөө танигдахгүйгээр хэрхэн биг дата үүсгээд, төр тэрийг Үндэсний статистикийн хороо судалгаандаа ашиглаж болох вэ гэдэг асуудал бирчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр ерөөсөө би энэ хувь хүний нууцын мэдээллийг шууд хувиргадаг, танигдахгүйгээр хийх боломжийг л энэ удаагийн хуулийн хүрээнд хийж өгөөч. Тэгэхээр бид нар энэ магадгүй холбогдох хуулийг нь анхны хэлэлцүүлэгт нь буцаагаад, ингээд Статистикийн газар ядаж жишээ нь ингээд биг дата үүсгээд, төрийн байгууллагын мэдээллүүдийг зайлиггүй нэгтгэх энэ шаардлага байгаад байгаа учраас энийг нэгтгэдэг энэ боломжийг нь хуулийн хүрээнд олгож өгөөч ээ гэдэг саналыг тавих гээд байгаа юм.

Тэгэхээр энэ бол үндсэндээ Статистикийн хороо гэдэг чинь үндсэндээ Улсын үндэсний судалгааны газар шүү дээ. Тэгэхээр энд бид нар биг дата үүсгэдэг, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг нийтийн мэдээлэл болгож хувиргаж ашигладаг биг дата судалгаанд ашигладаг болох л гарцуудыг нээхгүй бол үндсэндээ судалгаа бүрэн утгаар хийгдэж чадахгүй болчхоод байгаа юм. Нөгөөх нь төрийн байгууллагууд мэдээллээ нэгтгэхгүй байгаад байна.

Г.Занданшатар: Учрал сайд Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ хуультай бол хамааралгүй л дээ. Яг энэ асуудал бол. Тэгэхээр энэ хууль нөгөө 120 салбарын хуулиудаар цахим хэлбэрээр бичиг цаасаа солилцох боломжийг үүсгэх буюу нөгөө И-монголын 4.0-ыг иргэдэд хүргэх гээд байна шүү дээ. Тэгээд и-монгол дээр чинь хөгжлийн бэрхшээлтэй иргэний ай ди байгаад байна. Студент ай ди байгаад байна. Жолооны үнэмлэхийн ай ди байгаад байна. Гэтэл нөгөөдхийг чинь цаасаар нэхээд байна. Эрүүл мэндийн салбар цахимаар бичиг солилцох гэхээр заавал архив нь цаасаар байх ёстой гэхээр цахимаар явуулсан юмыг хэвлэж хадгалаад байна гэхээр ийм илүү ажил хийлгээд байгаануудыг салбарын хуулиудаар нь зохицуулаад төрийн байгууллагуудыг ажил хийх нөхцөлөөр нь хангая гэдэг зорилгоор л оруулж ирээд байгаа юм.

Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулиар хүний эмзэг мэдээлэлд хамаарч байгаа асуудлууд бол хувь хүний нууцад шууд хамаарна. Нууцаар хамгаалагдана. Тэгэхээр биг датаг болгох ажил бол угаасаа хийгдэж байгаа. Тэр 606 жагсаалт бол Статистикийн хороо манайх 2 нийлээд хийж байгаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн 81.

С.Тэнгис: Тэмүүлэн гишүүний асуултад тодруулж хариулъя. Цахим хөгжил харилцаа холбооны сайдын зөвлөх Тэнгис байна. 2021 оны 12 сарын 17-нд буюу 2 жилийн өмнө батлагдсан Цахим хөгжлийн багц хууль байгаа. Цахим хөгжлийн багц хуулиар Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд бол төрийн байгууллага хувь хүний мэдээллийг тодорхойлох боломжгүй болгож өөрөөр хэлбэл, нөгөө анонимос болгоод тэгээд нээлттэй өгөгдөл, статистикийн зорилго, түүх, эрдэм шинжилгээний зорилгоор ашиглаж болно гээд хуульчлаад нээчихсэн байгаа. Мөн Цахим хөгжлийн багц хуулийн нөгөө нэг хэсэг нь болох Нийтийн мэдээлэл ил тод

байдлын тухай хуулиар төрийн аливаа буюу тухайн хуульд заасан хаалттай, нээлттэй, хязгаарлагдмал бүх төрлийн мэдээллийг мөн хувь хүнийг тодорхойлох боломжгүй болгож нээлттэй өгөгдөл болгон статистикийн зорилгоор боловсруулах тийм боломжийг бас нээгээд өгсөн байгаа. Хууль маань 2022 оны 5 дугаар сар 1-ээс хүчин төгөлдөр болсон. Мөн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд НӨАт-ын баримт.../минут дуусав/

Г.Занданишатар: Нямосорын Учрал сайд гүйцээгээд хариулчихъя. Микрофонд хэлчихье.

Н.Учрал: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл. Төрийн байгууллага хүнийг тодорхойлох боломжгүй болгож мэдээллийн эзний мэдээллийг нээлттэй өгөгдөл болгоно гээд энэ хуульд бол заачихсан. Дээрээс нь хуулийн 17.7 дээр хэрэглэгчийн систем нийлүүлэгчийн дамжуулсан төлбөрийн баримтын мэдээллийг доор дурдсанаар бусад этгээд танилцах эрхгүйгүй. Задруулахыг хориглоно гэдэг дээр нөгөө шууд мэдээлэл нь хамаарч байгаа болохоос яг нөгөө эзэн холбогдогч нь тогтоогдохгүйгээр биг дата болгох бол бололцоотой. Биг дата гэдэг бол нөгөө боловсруулагдаагүй мэдээлэл. Нөгөө иргэн Батаа яг хэдэн төгрөгийн ямар бараа бүтээгдэхүүн авсан биш, тухайн бүс нутагт хэдээс хэдэн насны хүмүүс хэдий хэмжээний бараа бүтээгдэхүүн хэдэн төгрөгөөр авч байна вэ гэдэг ерөнхий нөгөө биг дата. Тэгээд тэр биг датаг ил болгох юм бол шийдвэр гаргалт ч ухаалаг болох нь байна. Нөгөө хувийн байгууллагууд ч гэсэн бизнесээ явуулахад хэрэгцээтэй гэдэг тэр Тэмүүлэн даргын яриад байгаа саналыг бид нар яг статистиктай хамтраад ажиллаад явж байгаа.

Г.Занданишатар: Ганзоригийн Тэмүүлэн Төсвийн байнгын хорооны дарга. Энэ бас яг чухал асуудал болоод

байгаа юм. Хуулийн зөрчил гарчхаад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Учрал сайд, сая нөгөө нийтийн мэдээллийн тухай хууль дээр яг саяын заалт бол байгаа. Энийг хуулиараа ингээд бид нар чинь хувь хүний нууцлалын мэдээллийг нийтийн мэдээлэл болгож хувиргаад аваад ашиглая, биг датадаа ашиглая гэхээр хуулиар өгөх боломжтой хэдий ч тэр юу гэдэг юм 3 сая иргэнд и-монголиагаар мэдэгдэл хүргүүлэх болчихоод байгаа юм. Тэгээд л нэг мэдээлэл аваад л бүх хүнд дахин мэдэгдэл хүргүүлдэг ийм тогтолцоо болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь нэг талдаа төр шийдвэр гаргахын тулд судалгаа хэрэгтэй. Тэгэхээр тэрийг магадгүй хувь хүнийх нь нууцлалынх нь үүднээс хувиргаж биг датад ашигладаг л судалгаанд ашигладаг л ийм орон зайг хуулийн хүрээнд үүсгэх хэрэгтэй болчихоод байгаа юм. Тэгэхээр энийг жишээ нь энэ дээр зохицуулалт хийж болохгүй юм уу. Биг дата болгоё гэхээр иргэнээ эхний ээлжид таньж, тэгээд биг датаны суурь бий болох л энэ шаардлага болчихоод байгаа байхгүй юу.

Г.Занданшатар: Яг хууль, эрх зүйн талаас нь энэ зохицуулалтыг сайдын зөвлөх хариулъя. 81.

С.Тэнгис: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар хүний мэдээллийг хуульд заагаагүй буюу хуульд заагаагүй зорилгоор эсвэл гуравдагч этгээд ашиглах үед бол мэдэгдэл хүргэнэ гэж заасан байгаа. Тэгэхээр хэрвээ энэ тохиолдолд үнэхээр тийм хууль хэрэглэний асуудал үүсэж байгаа бол тухайн хүний мэдээллийг жишээ нь статистикийн байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд тэр хүний мэдээллийг авч ашиглаж байгаа учраас мэдэгдлийг хүргэхгүй бас байж болно. Мөн тухайн хүний мэдээллийг татварын алба буюу мэдээлэл хариуцагч өөр дээр нь тодорхойлох боломжгүй

болгоод авч байгаа тохиолдолд мөн статистикийн байгууллагад шилжүүлэхэд бас мэдэгдэл хүргэхгүй байх тийм боломж нь бол уг нь байдаг.

Г.Занданшатар: Энэ асуудлыг дараа нь жич тайлбарлана. Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууя.

С.Бямбацогт: Баярлалаа. Тэгэхээр төр хүнд сурталтай байна, авлигалтай байна, шударга бус байна, данхар том байна гээд байгаа асуудал үндсэндээ л бас энэ төрийн үйлчилгээтэй холбоотой л доо. Тэгэхээр энэ төрийн үйлчилгээг яаж ил тод болгох вэ, нээлттэй болгох вэ, хүнд сурталгүй болгох вэ, авлигалгүй болгох уу гэдэг асуудал ерөөсөө л энэ төрийн үйлчилгээг цахимжуулах. Хүнээс үл хамааралтай болгох. Өнөөдөр төрд байгаа мэдээллийг төрийн албан хаагч үндсэндээ өөрийнхөө давуу тал болгож ашигладаг. Иргэдийг зовоодог, ядраадаг, залхаадаг. Ингээд эцэстээ энэ шан харамж болдог, эцэстээ энэ цаашаагаа авлига, хээл хахууль болдог. Үүнийг л шийдэхийн тулд Монгол Улсын Их Хурал бас үе шаттайгаар хуулиуд батлаад явж байгаа. Албан тушаалын хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг болсон. Улсын бүртгэлийн багц хуулиуд баталсан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль баталсан. Хувь хүний нууцын тухай хууль баталсан. Кибер аюулгүй байдлын тухай хууль баталсан. Энэ хуулиуд дээр бол манай Учрал сайд бол бас яг ажлын хэсгийг нь ахалж голлож, анхаарч ажилласан. Тэгээд анх удаагаа бас Цахим хөгжлийн яам байгуулагдаад сайдыг нь хийж байгаа. Тийм болохоор эхнээсээ үзэл баримтлал зорилгоо бол маш сайн ойлгож байгаа. Өнөөдөр хэлж байна шүү дээ, төрсний гэрчилгээ шаарддаг, иргэний үнэмлэх шаарддаг, Эрүүл мэндийн даатгалын дэвтэр шаарддаг, нийгмийн даатгалын дэвтэр шаарддаг, тэгээд жолооны үнэмлэх, гэрлэлтийн бүртгэл юу гэдэг юм ингээд л эх захгүй баахан юм шаарддаг. Энэ шаарддаг байдлыг л болиулах гэж байгаа. Төр өөрт

байгаа мэдээллээ бусдаас шаарддаг. Энүүгээрээ үндсэндээ хүнд суртал гаргадаг. Ингээд шан харамж авдаг. Үүнийг л шаардахгүй болох гэж байгаа юм.

Төлбөрийн картууд гэхэд өчнөөн олон банк байна. Худалдаа хөгжлийн, Хааны, Голомтын юу гэдэг юм ингээд өчнөөн олон банкны төлбөрийн карттай. Гар утас ялгаа байхгүй. Сүлжээ барьдаггүй. Гар утасны компани болгон уулын мухарт антен зоочихсон. Мобикомын антен, Жи мобайлын антен, Юнителийн антен. Илүү зардлууд. Дээрээс нь хүн болгон тэр гар утасны антенд нь тааруулаад 3 гар утас барьдаг. Иймэрхүү байдлуудыг л гол нь байхгүй болгох гээд л и-монголиа 4 болгоод, цаашилаад хурдан систем, shilen.gov.mn гээд иймэрхүү байдлаар үндсэндээ том биг дата Монгол Улс үүсгэе. Монгол Улс нэгдмэл бодлоготой байя, нэгдсэн сантай байя, үүнээсээ иргэддээ төрийн үйлчилгээг хурдан шуурхай гэрээсээ, гар утаснаасаа авах бололцоо боломжийг л бүрдүүлье гэж байгаа юм.

Заавал түгжрэлд ороод, гэрээсээ гараад түгжрэл дунд явдаг, заавал юу гэдэг юм гэрээсээ гараад сумын төв орж байж, аймгийн төв орж байж төрийн үйлчилгээ авдаг биш гэрээсээ гар утаснаасаа үйлчилгээ авдаг бололцоотой болгох энэ чухал байгаа юм. Тийм болохоор үндсэндээ бол ард иргэдэд бас энэ 92 хуулийг өөрчилж баталснаараа гэрээсээ гар утаснаасаа төрийн үйлчилгээ яаж авдаг болох юм. Энийг бас нэг сайн тайлбарлаад өгөөч. Өөрөөр хэлэх юм бол ийм олон гар утастай байх хэрэгтэй юм уу. Олон гар утастай байхын тулд заавал Жи мобайлын антен гээд төр зардал гаргадаг. Юнителийн антен, Мобикомын антен гээд баахан зардал гаргах шаардлагатай юм уу. Ингэхгүй заавал гар утасныхаа дугаартайгаа шилжчихдэг гар утасныхаа дугаараараа ерөөсөө бүх төрлийн сүлжээг нэг дор авчихдаг нэг л

антен байхад тэр бүх төрлийн сүлжээ ажилладаг яагаад байж болдоггүй юм?. Гар утаснаасаа бүх төлбөрийн картуудыг, бүх төлбөрөө банкныхаа төлбөрийг хийчихдэг, дэлгүүрээс худалдан авалтаа хийчихдэг, таксиныхаа мөнгийг төлчихдөг. Иймэрхүү байдлаар нэг их олон юм кармалж авах шаардлагагүй болох бололцоотой юм уу. Нэг ийм л асуудлуудыг шийдмээр байгаа юм л даа. Ингээд нэгдсэн 1 дататай, нэгдсэн 1 бодлоготой, нэгдсэн 1 системтэй болмоор байна. Яг үүнтэй уялдуулаад бас бодлого маань бас нэг баймаар байгаа юм.

Түрүүн Хүрэлбаатар сайд бас ярьж байгаа. Монгол Улсыг нэгдсэн нэг тойрог болгоё. Бүсчилж бас тойрог болгоё. Дандаа нэг жалга довны гэдэг юм уу дандаа тусгаарласан, ганцаардалсан, ялгаварласан ийм олон салангид биш нэгдсэн 1 бодлоготой нэгдсэн 1 тойрогтой ч юм уу ийм байдлаар бид нар нэг жалга дов, аймаг гэдгээрээ хуваагдах биш энэ бодлогуудаа нэгтгэе. Бодлогоо нэгтгэхийн тулд бодлого тодорхойлдог Их Хурлын гишүүдийн тойргийг нэгтгэе. Иймэрхүү юмнуудыг бас нэг давхар бас бодох ёстой байх. Тэгээд үүний эхлэл нь үндсэндээ бол яг ингэх ёстой юм байна гэдэг эхлэл нь үндсэндээ энэ төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх энэ бодлого гэж харж байгаа. Энэ м-монголиа энэ хур, дан систем. Дээрээс нь түрүүн ярьсан тэр гар утас.../минут дуусуув/

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Төрд15 янзын бичиг хэрэг солилцооны систем байсан. Тэгээд хоорондоо бичгээ шийдэж чаддаггүй. Тэгээд сая дунд нь нэг холболт хийгээд одоо хоорондоо бичгээ солино шүү гэхээр цахимаар явуулж байгаа бичгүүдээ хэвлээд л хадгалаад байдаг. Тэгээд яагаад ингээд байгаа юм бэ гэхээр хуульд нь ийм шүү дээ гээд ийм тайлбар хэлээд байдаг. Тэгээд энэ хэдэн өдөр энэ нүүрсний

сонсголыг хүмүүс анхааралтай ажиглаж байна л даа. Тэр нүүрсний сонсгол дээр бүр арай хэтэрхий юмнууд яригдах юм. Хэдхэн жилийн өмнө томилсон шийдвэрээ олохоо больчихсон гэж байгаа юм. Хоорондоо бичгээр явуулсан бичгүүдээ хаана байгаагаа мэдэхээ болиод устгачихсан гээд байгаа юм. Тэгээд ямар ч баримт байхгүй. Тэгээд ерөөсөө энэ архив руу эргэж харахгүй бол цахимаар үүсэж байгаа архив гэдэг ойлголт бараг байхгүй байна шүү дээ. Одоо өргөдөл гомдлуудыг төр лүү и-мэйлээр явуулахад эргээд иргэнээс ирсэн и-мэйл нь албан бичигт тооцогддоггүй. Өнөөдрийн хуулиар. Сая и-бизнесээр нөгөө үйлчилгээ авах гэж байгаа хүмүүст хүсэлтийг нь аваад зөвшөөрлийг нь олголоо л доо. Тэгсэн чинь зөвшөөрөл авсан ганцхан Кю ар код гарч ирээд л уншуулахад мэдээллийн санд нь энэ хүн зөвшөөрөл авсан үгүй нь мэдэгдэж л байгаа. Гэтэл хууль дээр нь заавал бичгээр, заавал цаасаар тэр нэг ийм үнэт цаас хэвлэх ёстой гээд хуульчилчихсан болохоор дахиад хэвлээд хадгалаад байдаг. Тэгээд гудамжинд ингээд цагдаа нар бичиг баримт шалгадаг. Яагаад та нар шалгаад байгаа юм бэ. Энэ и-монгол дээр чинь жолооны үнэмлэх чинь байна шүү дээ, иргэний үнэмлэх чинь байна шүү дээ гэхээр хуулиа хар гээд. Тэгэхээр нөгөө төрийн байгууллагын албан хаагчдыг буруутгах ямар ч арга байхгүй. Нэгэнт л тэнд чинь хуулиа дагаж л байгаа хүмүүс аргагүйн эрхэнд л ингээд байдаг. Тэгэхээр энэ 120 хууль төрийн албан хаагчдыг ажил хийх нөхцөл бололцоогоор хангаад, энэ дүрэм журмын түгжрэлийг тайлна л гэж. Дүрэм журмын саад тотгорыг арилгана л гэж зорьж л энэ салбарын хуулиудыг хийгээд байгаа юм. Өнөөдөр онлайнаар финтекийн маш олон аппликэйшнүүд гарчээ. Онлайнаар зээл авахад нийгмийн даатгалынх нь төлөлтийг нь, цалингийн мэдээллийг нь иргэний зөвшөөрснөөс нь хараад та тэдэн төгрөгийн зээл авна гэдгийг тооцоолоод хариу илгээчихдэг. Тэгтэл яг зээл авъя гээд кноп даръя гэхээр та

өөрийн биеэр ирж гарын үсгээ зурж, гэрээ байгуулаарай гээд. Ямар учиртай юм бэ гэсэн чинь нөгөө банк, санхүүгийн салбарын эрх зүйн орчин дээр нь өөрийн биеэр ирэх ёстой гээд хуульчилчихсан байна гээд байгаа болохоор цахимаар бас байж болно гэдгийг нь энэ дээр л хуульчилж өгч байгаа учраас дүрэм, журмын түгжрэлээс гарна л гэж бид нар найдаад байгаа юм.

Манай энэ харилцаа холбооны салбарт шинэ дэд бүтцийг эрэлхийлэх зайлиггүй шаардлагатай байгаа. Тийм учраас Харилцаа холбооны хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг өнгөрсөн 5 сарын хугацаанд манай дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаад, удахгүй өргөн барих гэж байгаа. Тэгээд бид нарт хэд хэдэн ийм шийдлүүд байгаа. Монголын иргэн болгон кармандаа 4 янзын дугаартай явдаг юм байна. Тэгээд энд Мобиком барьдаг, энд Юнител барьдаг, энд Скайтел барьдаг гээд ээлжилж гаргаж ирж ярьдаг. Гэтэл гадаадад гар утастайгаа очсон хүн тэр интернэйшнал роуминг үйлчилгээ буюу аль дэд бүтцийг нь тэнд барьж байна шууд холбогдоод тухайн сүлжээгээр дамжуулаад л өөрийнхөө хэрэглэж байгаа операторынхоо тусламжтайгаар ярьдаг интернэйшнал роуминг. Тэгэхээр бид нар шинэ дэд бүтэц эрэлхийлэх ёстой учраас энэ Харилцаа холбооны хууль дээр энэ Бямбацогт сайдын ярьж байгаа санаачилгуудыг тусгаж оруулж ирж байгаа. Энийг бид нар ярьж хөдөө орон нутагт аль компани ямар дэд бүтэц барьж байгуулсан байна түүнд нь суурилоод өөрийнхөө аль ч операторын утсыг хэрэглэж байгаагаас үл хамаараад ярьдаг болох. Ингэж байж нөгөө энэ иргэнээ хайдаггүй, иргэнээ хамгаалдаг ийм нөхцөлийг бас бүрдүүлнэ. Тэгээд ажлын.../минут дуусав/

Г.Занданшатар: 81. Сайдын зөвлөх Тэнгис хариулъя.

С.Тэнгис: Бямбацогт гишүүний асуултад тодруулж хариулъя. Яах вэ, ер

нь нөгөө харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарт бас манай Монгол Улс чинь өөрөө нөгөө чөлөөт зах зээлийн өрсөлдөөнтэй хөгжиж байгаа салбар. Тэгээд технологийн салбар финтекүүд бас чөлөөт өрсөлдөөнийхөө ачаар бас энэ бүс нутагтаа олон улсад бас амжилттай олон бүтээгдэхүүн үйлчилгээг жишээ нь гаргаад байгаа. Эшшээ нь Киргиз, Узбекистан гэдэг улсуудад бол манай залуучууд ингээд бүтээлээ гаргаад явж байгаа. Бас нэг ийм давуу тал байгаа. Нөгөө талаасаа тэрийг бас төрийн байгууллагууд бас заавал давхиулж бас нөгөө аваад байгаа чинь өөрөө бас нөгөө татвар төлөгчдийн мөнгийг бас үргүй зарцуулаад байгаа үзэгдэл харагдаж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг шийдвэрлэхээр 2021 оны 12 сард батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд төрийн байгууллага мэдээллийн систем үүсгэхээр бол давхиулахгүйгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас зөвлөмж, дүгнэлт авахаар хуульчилсан. Тэр зөвлөмж, дүгнэлт нь болохоор системүүдийн уялдаа холбоотой байдал, эдийн засгийн үр ашигтай байдал гэх мэтчилэн тэр давхардаад байгаа зүйлсийг арилгахаар хуульчлаад өгсөн байгаа. Мөн сүүлд Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуульд бас сүүлд нэмэлт орсон. Ирэх жилээс хэрэгжиж эхэлнэ. Төрийн байгууллага мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой худалдан авалт хийхээр бол Цахим хөгжлийн яамнаас тэр мэргэжлийн системийн тэр давхцаж байгаа юм уу, үгүй юм уу, ашигтай юм уу, ашиггүй юм уу гэдэг системтэй холбоотой зөвлөмж, дүгнэлтийг авсны дараа худалдан авалтаа зохион байгуулахаар ийм зохицуулалтуудыг бол тусгаж өгч байгаа. Тэгээд ирэх жилээс бол энэ асуудал бол шийдэгдэнэ. Манай яамны харьяалах асуудлын хувьд харилцаа холбооны сүлжээнд тэр олон утастай, олон дугаартай ингээд 4, 5 оператор ажиллаад байгаа асуудлыг бас тодорхой хэмжээнд шийдэх зорилгоор

дугаартайгаа шилжих үйлчилгээг бас олон жилийн өмнө хуульчлаад бас төдийлөн амьдралд нэвтрэхгүй бас үзэгдэл харагдаж байна. Тэгэхээр тэрний дараагийн шийдэл буюу хүн заавал дугаартаа шилжихгүйгээр түр хугацаанд сая Учрал сайдын хэлсэн шиг тухайн нэг зөвхөн Скайтелийн сүлжээ ч юм уу барьдаг тэр аялал жуулчлалын бүс нутаг, уул уурхайн бүсэд яг тэр тухайн хугацаандаа өөр операторын сүлжээг Эмерженси ч юм уу зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэхээр бид нар олон улсын цахилгаан холбооны байгууллагаас энэ оны 1 сараас эхлээд зөвлөх үйлчилгээ аваад, энэ 12 сард өнгөрсөн 7 хоногт дөнгөж энэ зөвлөх үйлчилгээнийхээ тайланг хүлээж аваад байгаа. Энэ зөвлөх үйлчилгээний тайлангийн хүрээнд бид нар Монгол Улсад нэйшнал роуминг буюу би өөрийнхөө ашигладаг хүмүүст танигдсан дугаартайгаа энэ операторуудын сүлжээг ашиглахад ямар эдийн засгийн үр нөлөөлөл боломж давуу тал гарах вэ гэдэг тэр зүйлсийг бол тусгасан. Бид нар хүлээж аваад Харилцаа холбооны хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгахаар ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн тодруулж асууя.

С.Бямбацогт: 20 жилийн өмнө гар утаснаасаа мэдээлэл авдаг, гар утаснаасаа банкны төлбөр хийнэ гэх юм бол хүн төсөөлөхгүй байсан. Одоо хүн болгон гар утаснаасаа мэдээлэл авдаг. Телевиз үзэхээ больчихлоо, сонин уншихаа больчихлоо. Банкны төлбөрийг шууд хийдэг болчихлоо. Үүнтэй адилхан л төрийн үйлчилгээг гар утаснаасаа, гэрээсээ гарахгүйгээр л төрийн үйлчилгээг авдаг болчихмоор байгаа юм л даа. Энэ л Монгол Улсын Засгийн газрын, Их Хурлын зорилго бол энэ. Энийг явуулахад саад болж байгаа хуулиудыг ингээд 120 хуулийг шийдэх гэж байгаа юм байна. Шийдэх гэж байгаа юм байна. Тэгвэл нөгөө талдаа гэрээсээ гарахгүйгээр гар утаснаасаа төрийн үйлчилгээг авахад ч тэр гар утас нь

саадгүй ажиллаж байх бололцоогоо л бүрдүүлмээр байна л даа. Тэгэхгүй болохоор өнөөдөр яаж байна. Очоод зөвхөн Жи мобайлийн сүлжээ ажилладаг. Мобиком антен тавих ёстой. Дахиад Юнителийн антен тавих ёстой гээд баахан хөрөнгө оруулалт улсын төсвөөс ч гардаг, хувийн компани ч тавихад бөөн юм болдог. Тэгвэл тэнд нэг антен л байгаа бол бүх төрлийн утас ажилладаг баймаар байна. Энийг утас сонгосон бол 99-тэй байна уу, 88-тай байна уу, 95-тай байна уу тэр дугаараа.../минут дуусав/

Г.Занданшатар: Асуултад хариулъя. Гүйцээж асууна гэсэн юм байхгүй л дээ. 1 минут л нэмж хариулт хангалтгүй л бол. 30 секунд биш 1 минут байна. Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас яг эндээс зөвлөх үйлчилгээ авъя гээд бид нарт бас дүгнэлтээ ирүүлсэн. Харилцаа холбооны хуулийн нэмэлт, өөрчлөлтийг удахгүй Их Хуралд өргөн мэдүүлнэ. Тэгээд энэ үеэр бас энэ шийдлүүдийг ярилцъя. Бид энэ салбарт дэд бүтцийг шинээр эрэлхийлэх гэж бол нэлээд хичээж байгаа. Үлдсэн 191 баг ирэх 2 жилд бол шилэн кабелиар холбогдох ажил өрнөнө. Дээрээс нь нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагуудад зөвшөөрөл өгсөн. Одоо ямар ч байсан хилийн боомтуудаар алслагдсан сум суурин газар Старлинг Спэйс Икс хуулийн дагуу ажиллаж эхэлсэн. Мөн Үндэсний хиймэл дагуулын төслийг хэрэгжүүлэхээр Францтай хамтарч ажиллаж байна. Сая Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр гэрээ зурсан. Ингээд бас Их Хуралд энэ гэрээний талаар бас олон улсын гэрээг өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Ер нь энэ цаашидаа дэд бүтцээ сайжруулахгүйгээр гар утас нь сайн ажиллахгүйгээр цаашидаа бол төрийн үйлчилгээ цахимжин аиргээд ойртоно.../минут дуусав/

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн тодруулъя. 1 минут.

С.Бямбацогт: Баярлалаа. Тэгээд бодлого нь зөв явж байгаа юм байна. Жоохон хурдан л үр дүн гаргаад, үр өгөөжтэй л олгочихмоор байна л даа. Одоо ингээд зарим газар 4 антентай. Юнител, Мобиком, Скайтел, Жи Мобайл гээд. Бөөн зардал. Зарим газар нь антен байхгүй. Антен тавих гэхээр үр ашиггүй байна гээд антен тавьдаггүй. Тэгээд зарим газраа хүмүүс сая өөрөө Учрал сайд хэллээ шүү дээ. 4 утас карманлаад явж байдаг. Иргэд нь ч 4 утас карманлаад эдийн засгийн хувьд хохиролтой. Тэгээд л сүлжээндээ тааруулж ярих гээд. 4 антен тавих гээд компани ч гэсэн, төр ч гэсэн тэр илүү зардал гаргаж байдаг. 1 антен л байгаа бол тэр антен дээр дурын сүлжээтэй хүн нь чөлөөтэй л ярьдаг баймаар байна шүү дээ. Заавал 4 гар утас худалдаж аваад 4 гар утасны төлөө илүү мөнгө зардал гаргаад явмааргүй байна шүү дээ. 1 л утаснаас тэр Жи мобайлаар бол Жи мобайлынхаа дугаараар, Моби бол Мобигороо, Юнител бол юнителээрээ ярьдаг л баймаар байна л даа. Ийм юмыг л хэзээ хурдан бүрдүүлэх вэ, яаж хурдан бүрдүүлэх вэ. Энэ дээр л та хэд маань анхаараад хурдан л хийгээд өгчих юм бол энэ ард түмэн алга ташна. Бүгдэд л тэгш боломж бий болгомоор байна. Тэгэхгүй хэн нэгэнд давуу байдал байлгамааргүй байна.../минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэллээ. Эрхэм гишүүд ээ, одоо санал хураалт явуулна. 93 санал байгаа. Тэгээд энэ хууль бол яах вэ олон чухал асуудлуудыг хөндөж байгаа ч гэсэн энэ хууль бол зүгээр хууль, тогтоомжийн уялдаа холбоог хангаж, цаасан суурьтай баримт шаардах хүнд суртлын халыг халах гэж байгаа л хууль шүү дээ. Цахим гарын үсгийн тухай хуулиа амилуулах гэж байгаа хууль. Бусад технологийн болон техникийн шийдлийн асуудлууд бол энэ хуулиар зохицуулагдаж байгаа юм биш. Бид нар нөгөө баталсан цахим хөгжлийг дэмжсэн багц хуулиудад бичгээр гэсэн нэр томъёоны агуулгад бол цаасан эсвэл цахим хэлбэрийн аль алиныг хамааруулж ойлгохоор заасан байгаа.

Гэсэн хэдий ч бусад салбарын хууль дахь бичгээр гэснийг хэрэгжүүлэхдээ зөвхөн цаасан хэлбэрт байгаа бичгийг тооцож ойлгож хэвшиж ирсэн. Одоо бүх хуулиудад цаасаар юм өгнө, ийм бичиг авч ирнэ гээд ингээд заачихсан. Зарим жишээг дурдах юм бол энэ Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 430 хуулийг судалж үзэхэд зөвхөн бичгээр буюу цаасан хэлбэрээр гэсэн агуулга буюу үг хэллэгтэй 169 хуулийн 869 хэсэг байгааг тогтоосон байгаа. Ингээд цаасаар, өөрийн биеэр, хуулбараар, бичгийн хэлбэрээр хүргүүлнэ гэсэн энэ цаасан суурьтай баримт бичиг шаарддаг энэ хуулийн шаардлагуудыг л өөрчилж байгаа ийм хууль. Төрийн үйл ажиллагааг ингэж цахим хэлбэрээр явуулах хүн, хуулийн этгээд төрийн байгууллагаас авах үйлчилгээг цахимжуулах, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрдөг болох, нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 120 хуулийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлж энэ өөрчлөлтийг тусгасан. Гэхдээ энэ Учрал сайд, ажлын хэсэг нэг зүйл анхаармаар байна. Тэгээд нотлох баримтын хэмжээнд үнэлнэ гэж байгаа шүү дээ тээ. Мөнх-Оргил гишүүн энэ тэр ч гэсэн сайн мэдэж байгаа. Нотлох баримтыг цахим баримт бичгийг үнэлдэг боллоо гэхээр ингээд нотлох баримтыг бүрдүүлчихсэн байвал тэрнийг одоогийн хууль эрх зүйн орчинд хүнийг яриулж болж байгаа юм чинь үйлдэл хийлгэж болгож байна. Тэгээд тэр монтажийг л нотлох баримтад тооцохгүй гэж үзэж байгаа болохоос биш тэр чинь үргэлжилсэн юм байгаа байхгүй юу чинь гэх мэтчилэн энэ асуудлууд гарч байгаа учраас бас энийг дагуулж хууль, тогтоолын төсөл батлах зайлиггүй шаардлага гарч байна.

Ийм учраас нэг чиглэл санал хураалтын өмнө өгмөөр байна. Ирц бүрдтэл. Ийм учраас энэ хэлэлцээж байгаа асуудалтай холбогдуулж мэдээлэх

зорилгоор хэдэн зүйлийг хэлье гэж бодож байна. Дэлхийд дижитал хөгжил бол үсрэнгүй хөгжиж байна. Бид нарыг энэ хууль батлах гэж байх хооронд л энэ сарын өмнө Гитаб Капило танилцуулга хийгдсэн нь кодеруудын ажлын бүтээмжийг үлэмж ихээр нэмэгдүүлэх боломжтой шал ондоо болчихлоо. Кодерууд чинь бараг хиймэл оюун ухаан хийдэг болчихлоо. Өнөө өглөө гэхэд л Гүүгл компани Gemini AI Модел албан ёсоор танилцуулж байх жишээтэй. Өнөөдөр зарлагдсан Википедиагийн топ 25 хайлтын 1 дүгээрт энэ Chat GBT жагссан байна. Монгол улс цаашидаа энэ хиймэл оюун ухаан, машин, сургалт, их өгөгдлийн дүн шинжилгээг шийдвэр гаргахдаа түлхүү ашигладаг болох цаг үе бол аль хэдийн ирээд, бид хоцрогдож байгаа. Өгөгдлийн сан дэд бүтцийн боломж бүрдсэн гэж үзэж байна. Манай урд хөршид гэхэд Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо хамгийн гол байгууллагынхаа доор Үндэсний дата товчоо байгуулсан байна лээ. Энэ үндэсний дата товчоо бол өгөгдлийг нэгтгэх, хуваалцах, хөгжүүлэх ингээд машин анализ хийх бүрэн бололцоог бий болгож байна. Тийм учраас 2021 онд би энэ их өргөдлийн талаар ярихдаа бид өөртөө байгаагаа ашиглуулж чадахгүй байна. Бусдад байгааг өөрөө ашиглаж чадахгүй алдаа байна гэж хэлсэн. Энэ яг хэвээрээ л давтагдаж байна. Бид нар хэлбэрүүд нь сайжраад байгаа. Сая энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдсанаас хойш энэ хяналт шалгалтын хороодын үйл ажиллагаа энэ түр хороогоор нээлттэй сонсгол явж байна. Энэ дээр бол өгөгдлийн дүн шинжилгээ ашиглаж эхэлснээр авлига, хээл хахуулийн ул мөрийг олж илрүүлэхэд түлхэц болж байгаа. Ялангуяа нүүрсний хэргийн хяналтын сонсголд ашиглаж байгааг бас цохон тэмдэглэе. Ер нь тэр 44 их наяд гээд манай зарим хүн алдаатай ярьчихсан болохоос биш энийг нөгөө машинаар 3 байгууллагын зөрүү байгааг гаргаж ирээд л Гаалийн, Татварын, Хилийн мэдээллүүд зөрүүтэй

байгааг энэ 6 сард байгуулагдсан нүүрсний ажлын хэсгээс гарч ирээд л тэгээд л энэнээс ингээд дамжаад гарсан энэ ажил шүү дээ. Одоо энэ шилэн ажиллагааны хүрээнд энэ замбараагүй өгөгдлүүдийг цэгцэлж, дүн шинжилгээ хийх ийм боломжийг олгох хэрэгтэй байна. Ийм учраас Төсвийн байнгын хорооны даргын хэлж байгаа тэр саналаар Гааль, Татварын санхүүгийн мэдээллийг хувиргаж, хувийн мэдээлэлд хамааралгүй болгоод кодлоод, тэгээд нийтэд ил тод болгохыг энд зааж өгөх хэрэгтэй. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар боломжтой боловч гаалийн газар эндээс анализ хийхээр өгдөггүй. Одоо бид нар өчигдөр, уржигдар татварын орчны иж бүрэн шинжилгээг их өгөгдлийн симуляц, нөгөө *tax benefit microsimulation* гэдгээр хийж үзэж байхад дата нь байхгүй учраас үр дүн нь буруу гараад байдаг. Ийм учраас энэ Үндсэний статистикийн хороо Үндэсний дата төвийг түшиглэсэн их өгөгдлийн үндэсний товчоо эсвэл нэгдсэн төвийг байгуулж төр, иргэн, хувийн хэвшлийг шаардлагатай мэдээ мэдээллээр дүн шинжилгээгээр хангах тогтолцоог бүрдүүлэх боломжтой гэж харж байна. Нөгөө аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал чинь, технологийн 4 дүгээр хувьсгал чинь Тэнгис ээ, эд зүйлийн интернэт чинь эндээс л бий болно шүү дээ. Ийм учраас энэ дээр анхаарч энийг ер нь тогтоол дагалдуулж гарах хууль, тогтоолын төсөлд боломж дээр ингэж гүйцээн боловсруулахыг чиглэл болгож байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.9, 8.10-д энэ дээр тодотгол хийж болох юм шиг харагдаж байна. Дагалдуулаад хууль 8.9, 8.10-ыг хөндчихсөн байгаа юм. Нийтийн мэдээллийн ил тод байдлыг ил болгоно гээд. Тэгээд энэ заалтыг хэлэлцэх үедээ гүйцээн боловсруулах чиглэл өгөөд, тэгээд саяын энэ гишүүдийн ярьж байгаа заалтуудыг нэмж хийгээд ингээд нэг ийм дижитал шилжилтээ бүрэн утгаар нь хийх бололцоог нэн ялангуяа

энэ их өгөгдлийн дата санг бүрдүүлэх, байгуулах, хэлэлцээр хөгжүүлэх энэ боломжуудыг нээсэн. Төр өөртөө байгаа мэдээллээ ашиглаж чадахгүй байна гэдэг маань бол бас бидний маш том сул тал болчихоод байгааг анхаарч ажиллая. Ийм чиглэл өгч байна. Ингээд санал хураалт явуулна.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12^а ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Монголын ирээдүй болсон хүндэт сурагчид та бүхэнд сурлага, спортын өндөр амжилтыг хүсэн ерөөгөөд, сур сур бас дахин сур гэж сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг чинь өөрөө тогтоно. Их сайн сурч, сайн мэргэжил эзэмшиж, улс орныхоо ирээдүйд их хувь нэмэр оруулахыг хүсэн ерөөе. Та бүхэнд амжилт хүсье. Сурлагын амжилт хүсье.

Санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 93 санал байгаа.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Инновац цахим бодлогын байнгын хороо дэмжсэн санал байна.

Нэг. Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Төслийн 1 дүгээр зүйлийн “18.4.10,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн

Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Энхбаярын Батшугар, Наянтайн Ганибал, Цагаанхүүгийн Идэрбат, Батсүхийн Саранчимэг цаашидаа “Ажлын хэсэг” гэнэ. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн байна. Санал хураалт явуулъя. 22 гишүүн дэмжиж, 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгээд дипвекийг /deer fake/ энэ нотлох баримтад яаж тооцох вэ гэдэг л асуудал. Одоогийн Эрүүгийн хуулиар бол хэцүү л байгаа юм байна лээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “гэснийг, 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон төсөлд нэмж тусгах:

“3 дугаар зүйл. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн. Санал хураалт. 53,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлийн “15.2 дахь хэсэг,” гэснийг “15.2 дахь хэсгийн “хүсэлтээ бичгээр” гэсний дараа” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн. Санал хураалт. 53,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Авлигын тухай хууль чинь өргөн барьсан хуулийн дотор байхгүй байх юм. Авлига, Арбитрын хоёрынх эхнийхэд нь байхгүй байх хасчихсан юм у. 53,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

“2 дугаар зүйл. Арбитрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “гарын үсэг зурна.” гэснийг “гарын үсгээр баталгаажуулна.” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн.

Хөндөгдөөгүй заалт нэмж болж байгаа юм уу. Энэ тэгээд яагаад энэ дээр байхгүй байгаа юм. Энэ шигтгэсэн нь юм уу. Санал хураалт явуулъя. Тийм би дэмжихгүй байгаа. Энэ тэгээд төслөөрөө үлдэх нь байна тийм ээ. Горимын санал байхгүй юу. Горимын санал байхгүй бол ингээд энэ дэмжигдсэнгүй. Төсөлөөрөө үлдэж байна. Бичвэр гэдгээр л үлдэх юм байна. Тэгээд энэ чинь Арбитрын тухай хууль нь тээ. 44.1 нь тээ. Тэгэхээр 44-ийн нэгээсээ хасагдчихаарза энэ ингээд төслөөр үлдэж болох юм байна ингээд байчихад болох л юм байна шүү дээ. Энэ санал дэмжигдсэнгүй.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд ер нь шүүхийн маргаан арбитрын маргаан дээр цаасан нотлох баримтыг бас ашиглаж болно шүү дээ. Дан цахим ингэж болохгүй.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалтад доор дурдсан агуулгатай 47.4 дэх хэсэг нэмэх:

“47.4.Цаасан хэлбэрээр давхар хадгалах цахим баримт бичгийн нэр төрлийг энэ хуулийн 6.1.11-д заасан жагсаалтад тусгайлан заана.” Санал гаргасан ажлын хэсэг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “мөн зүйлийн “4.1.14” гэснийг “4.1.15” гэж,” гэснийг хасах санал гаргасан. Ажлын хэсэг. Хууль зүйн байнгын хороо

дэмжсэн. Санал хураалт. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ тэгэхдээ хэрэгтэй заалт л хасаад хаячихлаа.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.5.5 дахь заалтын, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.3.1, 26.3.4 дэх заалтын, мөн зүйлийн 26.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 17.1-д заасан цахим хэлбэрээр” гэж, 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, дугаарыг өөрчлөх.

“2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.1, 26.3.4 дэх заалтын, мөн зүйлийн 26.4 дэх хэсгийн “өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэх” гэснийг “энэ тухай бүртгэлд тэмдэглэх” гэж тус тус өөрчлөх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тэгэхдээ ийм чухал хэл амтай маргаан шийдвэрүүд дээр бас энэ цаасан суурь энэ тэрийг ашиглаж байхгүй бол манайх бол кибер аюулгүй байдлын хувьд туйлын эмзэг байгаа шүү дээ.

Одоо Parliament.mn сайт гэхэд сая халдлагад өртлөө. Дидос системээр.

Тэгээд бүтэн 1 өдөр хакердуулж байгаа байхгүй юу. Ингээд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, холбогдох этгээдүүдийг эрэн сурвалжилж байна л даа. Тэгэхдээ л энэ бол Parliament.mn бас харьцангуй хамгаалалттай системд ингэж халдаж чадаж байгаа юм чинь энэ эмзэг мэдээллүүдийг тэгээд бас өөрчлөх энэ тэр эрсдэлийг бол кибер аюулгүй байдлаа л сайн хангах хэрэгтэй юм байна лээ.

5. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн, 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийн, 34 дүгээр зүйлийн

34.1.3 дахь заалтын, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн, “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 51,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “хэсэг, 33 дугаар зүйлийн 33.4.2 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэснийг “хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 33 дугаар зүйлийн 33.4.2 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж” тус тус нэмсүгэй.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Анар энэ сая нээгдэхгүй байна шүү.

9. Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1, 2 дугаар зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Валютын зохицуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “худалдах, зээлдүүлэх гэрээ,” гэснийг “худалдах, зээлдүүлэх гэрээг бичгээр, эсхүл цахим

хэлбэрээр,” гэж, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 3 дахь заалтын “нотолгоо бичгээр” гэснийг “нотолгоог бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Сахилга хариуцлагын байнгын хорооноос дэг сахиулахыг сануулъя. Та хэвээрээ л байгаа шүү.

10. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Гаалийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн, 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн, 90 дүгээр зүйлийн 90.2, 90.3 дахь

хэсгийн, 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 139 дүгээр зүйлийн 139.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 253 дугаар зүйлийн 253.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 255 дугаар зүйлийн 255.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2.2 дахь заалтын “мэдээллийн сүлжээгээр” гэснийг “цахим хэлбэрээр” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ оны онцлох яриа хүнээр Содномын Чинзориг гишүүнийг тодруулах нь зүйтэй юм байна.

3. Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн гарчгийн “амаар болон бичгээр” гэснийг, 145 дугаар зүйлийн 145.1.9 дэх заалтын “бичгээр” гэснийг, 241 дүгээр зүйлийн 241.2 дахь хэсгийн “амаар болон бичгээр” гэснийг тус тус хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Хүний эрхийн өдрөөр гардуулна. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ

12. Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Газрын тосны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 1 дүгээр зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15. Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын, 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын, 8.6 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсгийн, 25 дугаар

зүйлийн 25.4 дэх хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсгийн, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсгийн, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн, 55 дугаар зүйлийн 55.1, 55.3 дахь хэсгийн, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн, 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсгийн, 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсгийн, 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсгийн, 81 дүгээр зүйлийн 81.2.7 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн, “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.3 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн, 69 дүгээр зүйлийн 69.5, 69.6, 69.7 дахь хэсгийн, 70 дугаар зүйлийн 70.2, 70.3, 70.4 дэх хэсгийн, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсгийн, 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалтын, 78.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 19.2-т заасан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.4.6 дахь заалтын “тамга /тэмдэг/” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсэг” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Даатгалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн, 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2, 54.3 дахь хэсгийн, 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсгийн, 75 дугаар зүйлийн 75.1, 75.2 дахь хэсгийн “бичгээр” гэснийг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийн “бичгээр хүссэн тохиолдолд” гэснийг тус тус хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.6, 38.7 дахь хэсгийн, 39 дүгээр зүйлийн 39.2, 39.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн, 43 дугаар зүйлийн 43.2.7 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3.8 дахь заалтын “тамга /тэмдэг/” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсэг” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “6.3 дахь хэсгийн” гэснийг “6.2.2 дахь заалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Саяынх уначихлаа.

Энэ 6.2.2-ыг хөндөөгүй заалтыг яагаад хөндчихөж байгаа юм. 6.3-ыг хөндөж байхад 6.2.2 болгоод ингээд хөндөөгүй заалтыг техникийн алдаа байсан юм уу. Энэ заалт дэмжигдсэнгүй.

6.3 дахь гэсэн заалт энд чинь байхгүй байна шүү. 6.3 Энэ тэр ч байхгүй шүү дээ. Энэ дээр 6.3 гэж байхгүй. Саранчимэг гишүүн дэмжээгүй юм уу. Батсүхийн Саранчимэг гишүүн.

Б.Саранчимэг: Саяын санал дээр миний санал дэмжигдэхээр гарах байсан боловч энэ төхөөрөмж ажилласангүй. Энэ саналыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Г.Занданшатар: Саранчимэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Ахиад дэмжигдсэнгүй шүү дээ энэ чинь. Энэ Засгийн газар олон шат дамжлагаар хянагдаж байгаа. Ингээд байхгүй заалт оруулж ирж ингэж хууль будилуулдгаа болиорой. Батшугар гишүүн. Энхбаярын Батшугар гишүүн.

Э.Батшугар: Сая би уг нь дэмжсэн юм. Тэгсэн чинь энэ төхөөрөмж хурууны хээ уншихгүй болоод эсрэг гарчихлаа л даа. Тэгээд саяын саналыг ахиж санал хураалт явуулна уу. Хүчингүй болгож ахиж санал хураалт явуулна уу гэсэн горимын санал гаргаж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд анхааралтай. Батшугар гишүүний саналаар санал хураалт явуулъя. Цэвэгдоржийн Туваан гишүүн суудлаа суу. Одоо ингээд чуулганы танхимд нэг айл хэсэж байгаа юм шиг ширээ ширээ хэсээд яваад байдаг хэдэн хүн.

Санал хураалт. 51,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя. Ганцхан хүнээр зөрөөд байна шүү гишүүд анхааралтай. Хөөе Туваан гишүүн суудалдаа суу. Хүмүүс санал хураалт өгүүлэхгүй битгий хурал үймүүлээд бай. Туваан гишүүн. Сайд нар тойроод л ингээд л. Санал хурааа. Энэ төхөөрөмж ажиллахаа больчихлоо шүү. 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалт, 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 66 дугаар зүйлийн 66.3.2, 66.3.3, 66.3.4 дэх заалт, 66.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 66.2-т заасан цахим хэлбэрээр гэж”, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн дараа “Тайлбар: Энэ хуульд заасан “гарын үсэг” гэж Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4.1.14-т заасныг ойлгоно.” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Донорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувийн саналаар дэмжиж байна.

20.Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт ор оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх

хэсэг, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.3 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 5.5 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн, 6.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн, 6.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 10-т заасан цахим хэлбэрээр” гэж, 5.5 дугаар зүйлийн 19.3 дахь заалтын “тамга /тэмдэг/”

гэсний дараа “, эсхүл цахим гарын үсэг” гэж тус тус нэмсүгэй.” Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ заалт дэмжигдсэнгүй ээ.

Энэ бол чухал заалт юм. Жавхлан сайд эсрэг өгчихлөө. Батжаргал Жигжидийн Батжаргал гишүүн бас эсрэг өгсөн байна. Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Би санал хураалтад дэмжиж санал өгсөн чинь эсрэгээр гарч байна. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье ээ.

Г.Занданшатар: Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Хүчингүй болгох санал хураалт явуулъя. 57,9 хувиар саналаар санал дэмжигдлээ. Санал дэмжигдсэн учраас хүчингүйд тооцож, санал хураалтыг дахиж явуулъя. 54,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2. Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

“3 дугаар зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 3.7 дахь заалтын “тоон” гэснийг “цахим” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “6.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал байна. Санал хураалт. 57,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан системийг ашиглан цахим хэлбэрээр” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг,” “149 дүгээр зүйлийн 149.1.1 дэх заалт, 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэг,” “294 дүгээр зүйлийн 294.6 дахь хэсэг, 296 дугаар зүйлийн 296.2 дахь хэсэг,” “443 дугаар зүйлийн 443.16 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Концессын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, 18.5.3 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “18.5.3 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангаж цахим хуудсандаа

болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “амаар болон бичгээр” гэснийг “амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “танина” гэснийг “таньж, баталгаажуулна. Тус системээр таньж, баталгаажуулсан мэдээллийг хүн, хуулийн этгээдээс цаасан хэлбэрээр шаардахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэдээлэл хариуцагч цахим хэлбэрээр бүрдүүлнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гарсан ажлын хэсэг.

Энийг гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Тэмүүлэн гишүүн ээ, нөгөө түрүүний ярьсны дагуу таны саналыг 8.9 түрүүний 8.10 дахь энэ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль дээр хэрхэн яаж оруулж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийнхаа Учрал гишүүний хэлсэн саналын дагуу тэр зүйлийг нь эилээд силк хийгээд тэгээд энийг нөгөө төрийн албаны байгууллагуудыг үүрэгжүүлэхгүй бол мэдээлэл хариуцагч гэдэг маань төрийн албаны байгууллагуудыг үүрэгжүүлэхгүй бол хийхгүй байгаа учраас тийм ээ. Тэгээд энийгээ дагуулаад тогтоол санаачилчих. Энийг гүйцээн боловсруулах чиглэл өгсөн.

31.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж

тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал дэмжигдсэнгүй.

Шинжээчийн дүгнэлт нотлох баримт учраас цаасаар гарах ёстой юу, үгүй юу гэдэг асуудал байгаа юм. Энэ чинь дэмжигдэхгүй бол төслөөрөө үлдэнэ тээ. Энэ хөндөгдөөгүй заалтуудыг хөндчихсөн юм байна. Энхбаярын Батиугар гишүүн.

Э.Батиугар: Би сая уг нь дэмжсэн юм аа. Тэгсэн чинь энэ техник ажиллахгүй байх шиг байна. Тэгээд горимын санал гаргаж, түрүүчийн саналыг хүчингүй болгож, дахиж санал хураалт явуулахыг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Техник ажиллахгүй байгаа юм шиг байна гэсэн асуудал байхгүй. Техник бол ажиллаж байгаа. Цахим гарын үсгээ баталгаажуулсан хэлбэр гэдэг чинь. Батиугар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Энэ санал дэмжигдсэнгүй ээ. Энэ төслөөрөө үлдчихээр бас болохгүй болчихоод байна л даа. Ер нь энэ нотлох баримттай холбоотой асуудлуудыг ингэж цахимаар шууд бүрдүүлдэг чинь бас асуудалтай л байгаа юмнууд.

Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Дарга аа, би сая уг нь дэмжээд дарсан юм. Тэгээд энэ дутуу дарагдчихав уу. Тэнд эсрэг гарч, дахиж санал хураалгаад хүчингүй болгоод, дахиад хураалгаж өгөхийг хүсье ээ.

Г.Занданшатар: Шинжээчийн дүгнэлт чинь нотлох баримт байхгүй юу. Нотлох баримтууд бол. Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт. 56,4 хувийн саналаар Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

Санал хураалт дахиж явуулъя. Энэ өөрчлөлт нь бол арай зөв байгаа юм.

Ингэхээр нөгөө цахим гарын үсгээр баталгаажуулсан гэдэг нь алга болчихоод байгаа юм л даа. Төслөөр шууд цахим гарын үсэг болчихоороо бас болохгүй болчихоод байгаа юм.

Ер нь угаасаа тэр 23.4-ийг л хөндөхгүй. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Дарга аа, төхөөрөмжид гацалт үүсээд сая сөрөг гарчихлаа. Эсрэг гарчихлаа. Энэ саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хурааж өгнө үү. Уучлаарай.

Г.Занданишатар: Даваажанцангийн Сарангэрэл гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Сарангэрэл гишүүн саяын санал хураалтыг хүчингүй болгох санал гаргаж дэмжсэн. Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Анхааралтай. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32. Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Талдаа орох болоогүй ээ. 51,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Амарсайхан сайд. нэг хүний саналаар л энэ явж байна шүү. Болдын Жавхлан сайд өнөөдөр 2 цаг хоцорсон. Тэгээд сая дундуур нь гарч ороод санал

унагаж байна. Үүнийгээ анхаарч ажиллаарай. 51,3 хувийн саналаар. Өглөө хууль эцэслэн батлахад байгаагүй.

33. Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ Бат-Эрдэнэ гишүүн, сайд аа, энэ Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос гишүүдийн ирцийг өнөөдөр зарласан байна лээ. Тэгэхдээ хоцрогдлыг зарлаагүй байна лээ. Одоо хоцрогдлыг зарлах хэрэгтэй. Хоцорсон цаг, минутыг нь бичих хэрэгтэй.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Өмгөөллийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34. Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “бичгээр буюу цахим шуудангаар” гэснийг “бичгээр, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн “бичгээр” гэснийг “бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан

ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35. Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 3 дугаар зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36. Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Прокурорын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан системийг ашиглан цахим хэлбэрээр” гэж, 34 дүгээр зүйлийн 34.3, 34.4 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 33.1-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

37. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалтын “бичгээр” гэсний

дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Аубакир гишүүний араас Булгантуяа гишүүн гараад явчихсан учраас санал хураалтыг түр түдгэлзүүлье. Ирц хүрэхээ больчихлоо.

38. Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтын, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3, 12.4 дэх хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Одоо яг талдаа орж байна.

Ням-Осорын Учрал гишүүн үг хэлнэ. Горимын санал.

Н.Учрал: Санал хураалтад сая дэмжсэн боловч татгалзсанаар гарсан байна. Тэгэхээр энэ төхөөрөмж ажиллаагүй учраас горимын санал гаргамаар байна. Санал хураалтыг дахиж явуулж өгөөч ээ.

Г.Занданшатар: Ингээд төхөөрөмж буруу ажиллаад байгаа юм бол энэ бүх санал хураалт буруу гэсэн үг болно шүү дээ логик нь. Тийм учраас санал өгөхдөө л бид нар алдаад байгаа

болохоос биш энэ төхөөрөмжийн бас алдаатай юм байж магадгүй. Тэгээд ер нь гараа өргөвөл тоолох гээд бүүр удаан болдог юм. Орчин үеийн юмнаас бас хоцрогдож болохгүй. Энийгээ зөв л ашиглах ёстой. Санал хураалт Учрал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Үдийн цайны дараа цуглахгүй аягүй бол. Чинзориг сайд суучих. Тэгээд санал хураалт явуулъя. Хамгийн яриа онцлох хүн дээрээ нэмээд хамгийн цайсаг онцлох хүн болох нь байна шүү та. Санал хураалт. Адьшаа гишүүн ороод ирлээ. Ингээд хүчингүй болгох санал дэмжигдлээ. Хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя. Учрал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулаад 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

39. Сogтууруулах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн. Санал хураалт. 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

40. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим

хэлбэрээр” гэж, мөн зүйлийн 8.8 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан нийтийн мэдээллийн систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Инновац цахим бодлогын байнгын хорооны дарга Энхбаярын Батиугар.

Э.Батиугар: Би сая улам дэмжсэн юм. Тэгсэн чинь нөгөө төхөөрөмж хуруу уншихгүй тэгээд эсрэг гарчихлаа. Саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Тэгээд дахиж санал хураалт явуулъя.

Г.Занданшатар: Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт. Аубакир, Булгантуяа, Ундрaм гээд энэ байсан гишүүдийг дууд. Бүлгийн дарга Тогтохсүрэн дарга та өөрөө дууд. Ирцээ бүрдүүлэх нь бүлгийн дарга үүрэг шүү. Санал хураалт. 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ саналыг дахиж санал хураалт явуулна. Хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж

явуулна. Санал хураалт. 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

42. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ хууль дэмжигдсэнгүй.

43. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “заалт, 62 дугаар зүйлийн 62.5 дахь хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

44.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 14.3, 14.6 дахь хэсгийн, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн, 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.3.3 дахь заалтын, мөн зүйлийн 19.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 14.1.3-т заасан цахим хэлбэрээр” гэж, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Адъяаа гишүүн ээ таны санал эсрэг гаргачихлаа. Та горимын санал гаргана уу. Таныг оны онцлох хүнээр шалгаруулна.

Ш.Адъяаа: Миний микрофон ажилласангүй. Дахиж санал хураалт явуулж өгөх үү?

Г.Занданшатар: Адъяаа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Ганбаатар гишүүн суу. Санал хураалт явахгүй байна. Санал хураалт. Бүлгийн дарга энэ арын хаалгаар чөлөө өгдөгөө болиорой. Санал хураалт явж байхад. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Дахин санал хураалт явуулъя. Санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя. Адъяаа гишүүний горимын санал дэмжигдсэн учраас санал хураалт дахиж явуулъя. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

45.Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Түрүүн тэр Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль байна шүү дээ. Тэр уначихсан шүү дээ. Тэр дээр цахимаар гэснийг нь төлөөний хүн гэдэг юм уу нөгөө асран хамгаалагч гэсэн байдлаар өөрчлөн найруулчих. Эцсийн хэлэлцүүлэг дээр.

46.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмсүгэй:”

“4/шинжээчийн мэргэжил, албан тушаал, шинжилгээ хийсэн газар, он, сар, өдөр, хугацаа.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн “54 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хугацаа бичигдсэн байна.” гэсний дараа “Шинжээчийн дүгнэлтийг цахим хэлбэрээр үйлдэх тохиолдолд цахим гарын үсгээр баталгаажуулна.” гэж,” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 2 дугаар зүйлд шилжүүлэх.”

“3/54 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Шинжээчийн дүгнэлтийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр үйлдэх бөгөөд бичгээр үйлдэх тохиолдолд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байна. Цахим хэлбэрээр үйлдэх тохиолдолд цахим гарын үсгээр баталгаажуулна.”Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

47.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

48.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 35.4-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

49.Улс төрийн намын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Улс төрийн намын тухай хуулийг буцаахгүй гэнэ. Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Саяын санал хураалтын саналын томъёололыг дэмжиж санал өгсөн. Эсрэг санал гарч байна. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Г.Занданшатар: Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт. Нямаагийн Энхболд гишүүн. Энэ заалт нэг их сонин.

Н.Энхболд: Сая уг нь би дэмжээд дарсан юм. Тэгээд энэ эсрэг гарчихсан байх юм. Та дахиад нэг санал хураалгаад, хүчингүй болгоод, эргээд санал хураалгаад өгөөч.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалтыг дахиж явуулъя. 53,8 хувийн саналаар санал дэмжээдлээ.

Тэгэхдээ ер нь Мөнх-Оргил гишүүний хэлснээр бол тэртээ тэргүй цахимаар авч байгаа бол тэгээд улс төрийн намын татан буугдсан мэдээллээ бичгээр болон цахимаар гаргаж болно гэдгийг л буцаачхаж л байгаа юм байна л даа. Болно.

51. Ул хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Ул хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.9 дэх хэсгийн, 42 дугаар зүйлийн 42.1, 42.2 дахь хэсгийн, 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. 53,8 хувийн санал дэмжигдлээ.

50 дахь саналыг санал хураалт явуулна.

50. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12^б ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт сурагчид та бүхэнд сурлага, спортын өндөр амжилтыг хүсэн ерөөж, сайн сайхныг хүсэн ерөөе.

Батжаргал, Нямаагийн Энхболд нарын гишүүд байж байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн сая энд байсан хаачив. Дуудаарай Адьшаа гишүүн ээ.

Одоо 28 санал үлдэж байна.

52. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “3 дугаар зүйлийн 7 дахь хэсэг,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

53. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Үнэнбат дарга аа, энэ оны онцлох хүмүүсийг бичиж авч байгаа биз. Энэ 3 дээр. Тэгээд би олон нийтэд мэдээлэх ёстой юм байгаа юм.

54. Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.1 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалтын, 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 24.2.1-д заасан цахим хэлбэрээр” гэж, 36 дугаар зүйлийн 36.8 дахь хэсгийн, “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

55. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн, 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсгийн, 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн, 65 дугаар зүйлийн 65.2 дахь хэсгийн, 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

56. Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэсний дараах “17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг хасаж, “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд бүлгийн дарга арын хаалгаар ширээнийхээ улсуудыг чөлөө өгч гаргаад байгаа учраас, танаас чөлөө авсан гээд л ингээд бичиг бичээд гараад явчихлаа. Ийм учраас санал хураалт явуулах нөхцөлгүй болж байгаа учраас чуулганыг 13 цаг болсон учраас завсарлуулаа 14 цаг хүртэл.

ЗАВСАРЛАГА.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2023 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудалдаа орно. Санал хураалтыг үргэлжлүүлнэ.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна. Анхны хэлэлцүүлгээр санал хураалтыг явуулж байгаа.

57 дахь санал хураалтаар санал хураалт явуулна. Улсын Их Хурлын гишүүд чуулганы танхимд санал хураалтад цуглая.

Тогтоолын төсөл дээр чинь юу яах гээд байгаа юм. Тэгээд гишүүд цуглалтал ярьж байхаас тогтоолын төсөл дээр чинь дэндүү ерөнхий заалт. Ингээд л цахим шилжилтийг хэрэгжүүлж

идэвхжүүлж энэ тэр гээд ингээд яг тодорхой тэр субъектүүдийг зааж өгмөөр байгаа юм. Тэгээд дээр нь тэр энэ кибер аюулгүй байдлын асуудлаа хангахгүй бол болохгүй байгаа юм. Тийм учраас цахим гарын үсэг маш сайн дэвшилүүд авчирна. Нөгөө талдаа эрсдэл гарахыг тооцож, цахим гэмт хэргийн талаар та хэдэд товч мэдээлэл өгье л дөө. Манай улсын цахим хэрэглээ бол тогтвортой өсөж байгаа. Энэ хэрээр цахим гэмт хэргийн тоо хурдацтай өсөж байгаа. Жишээлбэл, 2018 онд цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 659, 2019 онд 737 байсан бол одоо энэ 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 8818 цахим гэмт хэрэг бүртгэгдээд байна. 2018 онд нийт гэмт хэргийн 1,8 хувийг цахим орчин дахь гэмт хэрэг эзэлж байсан бол одоо нийт гэмт хэргийн 26,3 хувийг цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг эзэлж байна. Магадгүй цаашидаа бол нийт гэмт хэргийн 3-ны 1 нь энэ цахим орчинд хийгддэг болох эрсдэлтэй байгаа. Ийм учраас Байнгын хороо дээрээ та хэд яриад, ялангуяа энэ хүүхдүүдийг цахим орчны гэмт хэргийн хохирогч болохоос сэргийлэх чиглэлээр энэ тогтоолын төсөлдөө тусгах хэрэгтэй. Ер нь кибер аюулгүй байдлын чиглэлээр тусгах хэрэгтэй байгаа. Одоо бодитой эрсдэлүүдийг би ярилаа шүү дээ. Parliament.mn хакердуулж байна. Дата төв рүү хэчнээн мянган халдлагууд хийж байна. Тэгтэл энэ нөгөө цахим мэдээллийн системээр дамжиж байгаа цахим гарын үсэг энэ тэр маань хуурамчаар үйлдэгдэхгүй байх, хакердуулахгүй байх, бусад эрсдэлүүд энэ тэрээс ч хамгаалах арга хэмжээ авахгүй бол тэгээд ашигт малтмалын лицензээс авхуулаад энэ компани байгуулах тухай бүх асуудлуудыг ингэж цахимжуулж байгаа нь сайн боловч нөгөө талдаа гарч болзошгүй эрсдэлийг хязгаарлах асуудлыг тогтоолын төсөлдөө тусгахгүй бол хамгийн тодорхой жишээ би хэлээд байна шүү дээ. Шүүхийн тухай хуульд бол тасралтгүй монтаж хийгээгүй монтажжилсан л нотлох баримтад тооцохгүй гэж байгаа болохоос биш deer

fake чинь монтажжилсан биш үргэлжилсэн ийм юм юу байгаа байхгүй юу. Тэрнийг нотлох баримтаар тооцохгүй гэхэд тийм хууль эрх зүйн орчин байхгүй. Бас тэрнийгээ нотолж чадах уу, үгүй юу гэдэг нь үнэн юм уу, бодитой юм уу. Хүн амины гэмт хэрэг ч байдаг юм уу ямар ч хэрэг дээр ди фекээр юу ч хийж AI хийж болох ийм нөхцөлүүд үүсээд байна шүү дээ. Энэ тэрийг бас зохицуулахгүй бол сүүлийн үед гарч байгаа цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргүүд, цахим хаяг энэ тэр чинь 350 мянган хуурамч хаяг байна гэж байна шүү дээ. Тогтоочихсон. Бүр цахим гарын үсгийг хуурамчаар хийж өгнө гэсэн зар хүртэл явж байна шүү дээ. Ийм нөхцөлд эрсдэлгүй байна гэж бид тооцох ямар ч арга байхгүй. Тэр тусмаа манай кибер аюулгүй байдлын түвшин энэ бүс нутагтаа нэн ялангуяа бусад аюулгүй байдлын чиглэлийн асуудалтайгаа яаж уялдах энэ тэр гэдэг чинь харгалзаж үзэхээс өөр арга байхгүй. Энэ юмнуудаа бас тогтоолгохгүй бол дандаа ерөнхий утгатай цахим шилжилтийг эрчимжүүлнэ гэсэн тогтоол батлаад яах юм. Яг ямар ямар мэдээлэл энэ тэр гэдгээ тогтоол дээрээ сайн зааж өгөх хэрэгтэй.

Хэдхэн санал хураалт үлдсэн. Тэр сонсгол дээр байгаа гишүүд энэ тэрийг дуудаад. 8 гишүүн орж ирвэл санал хураалтаа явуулна. Сайн байна Адьшаа гишүүн. Таны карт уншигдаагүй байх юм. Адьшаа гишүүн ээ, уншигдчихлаа. Амарсайхан сайд, Амартүвшин гишүүн байна. Алтанхуяг, Анужин, Аубакир гишүүн, Аубакир гишүүн, Сүхбаатарын Батболд гишүүн байсан. Жигжидийн Батжаргал гишүүн, Дамбын Батлут гишүүн. Батжаргал гишүүн картаа сугалаад явчихсан байх юм. Аубакир гишүүн карт чинь уншигдаагүй байна. Уншуулчих. Сугалчихсан юм шиг байна. Батжаргал гишүүн, Батсуурь гишүүн. Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн байсан. Нямаагийн Энхболд гишүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд. Энэ ажлын хэсгийн дарга Жигжидсүрэнгийн

Чинбүрэн гишүүн хаачив. Дуудаарай. Ганзоригийн Тэмүүлэн, Чинбатын Ундрам.

Чинбүрэн гишүүн ээ, ажлын хэсгийн гишүүдээ дуудаарай. Санал хураалт явуулах гээд.

Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаад санал хураалтыг үргэлжлүүлж явуулна. Хэлэлцэж байгаа асуудлаар Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хууль болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулж, санал хураалтыг үргэлжлүүлнэ.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адъяаагийн урилгаар Ховд аймгийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эртний их дайчин удмын Урианхай түмний төлөөлөл болсон та бүхэндээ Олон улсын Хүний эрхийн өдөр, өнөөдрийн энэ бэлэг дэмбэрэлтэй өдрийг тохиолдуулаад хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Санал хураалтыг үргэлжлүүлж явуулна.

57.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн

“бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг гэсэн байна. Тэгээд санал хураалт явуулна. Саналыг дэмжсэн, дэмжээгүй үг гэж болно. Санал хураалт явуулна. Гишүүд суудлаа эзэлье. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“17.2.Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр болон энэ хуульд заасан цахим хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 12.4-т заасны дагуу ирүүлсэн баримт бичиг, эсхүл Нийтийн мэдээллийн дэд бүтцээр дамжуулан хүлээж авсан мэдээллийг хэвлэн авч, мэдээллийн санд оруулснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд тооцно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ компани байгуулах асуудал маш хөнгөвчлөгдөж байна гэсэн үг шүү. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Урианхай түмний төлөөлөлдөө баярлалаа. Уриа гэдэг үгнээс гаралтай гэж байгаа юм. Хан гэдэг үндэс язгуур залгаж уриан хан гэдэг байсан үгнээс гарсан байгаа. Уриалу, трүүлж манлайлагч нар байсан.

56,4 хувийн саналаар санал дэмжигдсэн.

58.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1.7 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 20.10-т заасан цахим хэлбэрээр” гэж, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “38.5.4” гэснийг “38.6.4” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

59.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Одоо 10 гаруйхан саналын хураалт үлдсэн байна.

60.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.1, 10.4 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн, 40 дүгээр зүйлийн 40.3, 40.5 дахь хэсгийн, 44 дүгээр зүйлийн 44.2, 44.4 дэх хэсгийн, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 25 дугаар зүйлийн

25.5 дахь хэсгийн, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн, 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсгийн, 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

61.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтын, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.5 дахь хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.4, 26.9 дэх хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 48.3 дахь хэсгийн, 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсгийн, 76 дугаар зүйлийн 76.4 дэх хэсгийн, 79 дүгээр зүйлийн 79.2 дахь хэсгийн, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсгийн, 81 дүгээр зүйлийн 81.6 дахь хэсгийн, 83 дугаар зүйлийн 83.4 дэх хэсгийн, 123 дугаар зүйлийн 123.3, 123.9 дэх хэсгийн, 132 дугаар зүйлийн 132.1 дэх хэсгийн, 148 дугаар зүйлийн 148.1, 148.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 142 дугаар зүйлийн 142.5 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

62.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 4 дүгээр

зүйлийн 4.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 87,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

63.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

64.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 58 дугаар зүйлийн 58.6 дахь хэсгийн “дарга нь” гэсний дараа “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан” гэж тус тус нэмсүгэй.” Санал гарсан ажлын хэсэг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

65.Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Цахим гарын үсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын, 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтын, 20 дугаар зүйлийн 20.3.3 дахь заалтын, 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 26.3-т заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

66.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.10 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 28 дугаар зүйлийн 28.2.7, 28.2.10 дахь заалтын, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

67.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “төлөөлүүлэгчээс бичгээр” гэсний дараа “эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр”, 56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 162 дугаар зүйлийн 162.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 180 дугаар зүйлийн 180.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 162.6-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

68.Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Шүүх шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

67.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

2.Төслийн 2 дугаар зүйлийн “33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт,” гэснийг доор дурдсанаар өөрчлөн

найруулж 3 дугаар зүйл болгон төсөлд нэмж тусгах:

“3 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх.

“2 дугаар зүйл.Шүүх шинжилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “гаргаж, гарын үсэг зурж, хувийн болон байгууллагын баталгааны тэмдгээр баталгаажуулна.” гэснийг “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулан цахим хэлбэрээр гаргана.” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

69.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “заалт, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Сүүлийн 5 саналаар санал хураалт явуулна. Сүүлийн 5 санал үлдэж байна.

70.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Гэрчилгээг цахим хэлбэрээр олгож

болно.” гэснийг “Гэрчилгээний мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан авах боломжтой.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Хуульд боломжтой гэж заах уу. Энэ найруулга дээр гэрчилгээг цахим хэлбэрээр олгож болно гэснийг өөрчлөх гэж байна шүү дээ. Тэгэхээр гэрчилгээний мэдээллийг төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан авч болно, ашиглаж болно, боломжтой гэж хуульд заахгүй л дээ ийм салаа утгатай.

71. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.15 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтын “бусад техник хэрэгсэл” гэсний дараа “, эрүүл мэндийн программ хангамж” гэж, 43 дугаар зүйлийн 43.2.7 дахь заалтын “бичгээр авах” гэсний дараа “, эсхүл бичгийг цахим хэлбэрээр авах” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62,5 хувийн саналаар дэмжигдлээ.

72. Хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар:

1. Төсөлд хуулиудын хүчин төгөлдөр болох хугацааг ердийн журмаар байхаар тогтоож, холбогдох өөрчлөлтийг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 67,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

73. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төсвийн байнгын хороо болон ажлын хэсэг, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Энхбаярын Батшугар нарын гаргасан саналын дагуу болон түрүүн ярьж хэлсний дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Чиглэл өгчихнө. Байнгын хороо дээр саналаа бичээд өгчих тэгэх үү. Таных бол нөгөө техникийн шинчлэлээр нөгөө нэг үйлчилгээ энэ тэрээ хэлж байна уу. Хүмүүс гараад явчих гээд байна гэнэ ээ. Тэр 2 дахь заалт ч гэсэн энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Инновац цахим бодлогын байнгын хорооны дарга Батшугарт даалгасугай гэж байна шүү дээ. Энэ чинь хамтдаа тогтоол дотроо явчихъя гэж үзье.

2. Инновац цахим бодлогын байнгын хороо дэмжээгүй санал байна.

1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 38.2 дахь хэсгийн “хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн. Инновац цахим бодлогын байнгын хороо дэмжээгүйн байна тээ. Санал хураалт. 4 гишүүн дэмжиж, Инновац цахим бодлогын байнгын хорооны санал унаж, Хууль зүйн байнгын хорооны санал дэмжигдлээ.

2. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“3 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 14 дүгээр

зүйлийн 14.1.3 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энийг чинь босгох санал юм уу. Дэмжих юм байна. Тэгээд амаар болон бичгээр гэсэн нь үлдчихлээ шүү дээ энэ чинь. Тэгээд энэ санал дэмжигдсэн. Энэ санал босож байна. Амаар болон бичгээр болоод. Хассан чинь босчихлоо. Харин энэ чинь хасагдчихаж байна шүү дээ. Амаар болон бичгээр гэдэг нь хасагдчихаж байна. Тийм байна.

Найруулгын санал.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл хэсэг, заалтын дугаар шилэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлье.

Энэ найруулгын саналыг дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ шүү. Тэгээд хэлсэн гарахгүй байна л даа. Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Энэ хууль батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлаас дагаж мөрдөх тогтоол баталж байгаа. Энэ тогтоол дээр бас зарим агуулга, зарим найруулгууд бас нэлээн орхигдчихсон. Найруулга нь бас жоохон тийм тодорхой биш харагдаад байгаа юм. Маш сайн хууль баталж байгаа. Төрийн үйлчилгээг ард иргэддээ бас цахимаар хүргэх, үндсэндээ төрийн хүнд суртал, төрийн албан хаагчдын ил тод, шуурхай ажиллах бололцоо боломжийг бий болгох зорилго агуулга маш зөв. Энийг хийж хэрэгжүүлэхэд нөгөө хонх нь дуугарахаар дамар нь таг байж болохгүй л дээ. Тэгээд төрийн байгууллага, иргэн дээрээс нь хувийн хэвшил бүгдээрээ л нэг зорилготой, нэг санаа бодолтой, нэг зүгт харж байж энэ хууль маань амжилттай хэрэгжинэ.

Тийм болохоор энэ тогтоол дотроо бас хэдэн агуулгууд оруулчихмаар байгаа

юм. Агуулга нь ерөнхийдөө байгаа боловч найруулгын хувьд нэг жоохон тийм албаны үгтэй жоохон ойлгомжгүй тодорхой бус байгаад байгаа юм. Тэгээд энийг нэг жоохон тодорхой болгоод, түүрүүн би хэлсэн шүү дээ. Ерөөсөө л гэрээсээ гар утаснаасаа төрийн үйлчилгээг төрийн болон бусад үйлчилгээг ерөөсөө иргэд маань шууд авдаг байх. Ингэхийн тулд нөгөө дэд бүтэц хэрэгтэй байгаад байгаа юм. Тэр гар утасны сүлжээнүүд, операторууд чөлөөтэй ажилладаг байх, тэр баг болгонд юу гэдэг юм заавал 4 компанид 4 антен тавьж илүү зардал гаргахгүй байх, гар утасны сүлжээ байхгүй газруудыг төр бас тийм сүлжээтэй болгох, сүлжээтэй болгосных нь дараа бас иргэн болгон заавал Мобикомоор, зөвхөн Жи Мобайлаар, зөвхөн Юнителээр ярьдаг биш ерөөсөө сүлжээ харгалзахгүй өөрсдөө сонгоод дурын сүлжээгээр ярьдаг байх. Ингэж байж нэг гар утаснаасаа, гэрээсээ төрийн үйлчилгээ авах бололцоо бүрдэнэ.

Тийм болохоор энэ агуулгаа бас нэг жоохон тодорхой болгоод Улсын Их Хурлаас нөгөө дагаж мөрдөх тогтоол дотор бас нэлээн сайн суулгаад өгчхөөрэй. Тэгж байж энэ хууль маань бас амьдрал дээр илүү бодитой үр өгөөжөө өгөх байх. Илүү иргэдэд энгийн ойлгомжтой тодорхой үгээр бас тогтоолд, бас дагаж мөрдөх журам дотор бас энийгээ оруулаад өгөх очоорой л гэдгийг хэлье. Тэгээд хамгийн гол нь гэрээсээ л гар утаснаасаа заавал хорооны байр луу очиж, заавал дүүргийн Тамгын газар, агентлаг руу очихгүйгээр түгжэрэлд орохгүйгээр Улаанбаатар иргэдийн төрийн үйлчилгээ авчихдаг. Заавал сумын төв орохгүй, аймгийн төв орохгүйгээр хөдөөгийн иргэд маань төрийн үйлчилгээ авчихдаг ийм байхын тулд лэнэ хуулийг баталж байгаа. Тийм болохоор энэ дээр нэг анхаараад бас дагаж мөрдөх тогтоолдоо энийг оруулчихаарай л гэж хэлье.

Г.Занданшатар: Санал хураалт явуулъя. Саналаа Инновац цахим

бодлогын байнгын хороонд бүүр бичээд өгчих юм уу, ороод хэлчихвэл хэлэлцүүлгийн үеэр, эцсийн хэлэлцүүлэг дээр. Санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Ажлын хэсэгт баярлалаа. 93 саналаар санал хураалаа.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах тухай хуулийн төслүүдийг оруулсан нэмэлт, өөрчлөлтийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац цахим бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно. Гишүүд суудалдаа суугаарай. Дараагийн асуудалд орно. Яаралтай асуудал. Маргаашийн нэгдсэн хуралдаанаар Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийг хангах тухай хуулийг Засгийн газраас өргөн барьсан байгаа. Үүнтэй холбогдуулан энэ хуулийн жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнгийн талаар Засгийн газрын тайланг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бичиг ирсэн байна. Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

14.45 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ